

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 03 дугаар сарын 21-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-3

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 4-27

<i>1.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.01.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	4-21
<i>2.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	21-27

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны
03 дугаар сарын 21-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Б.Энхбаяр ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 54 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Э.Бат-Амгалан, С.Бямбацогт, Б.Пүрэвдорж, Ц.Сандаг-Очир, Ц.Сэргэлэн, Н.Учрал, Д.Цогтбаатар;
Эмнэлгийн чөлөөтэй: Ш.Раднаасэд.

Нэг.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.01.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч Ш.Цолмон, шинжээч М.Гантуяа, Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн Албаны дарга Б.Баярсайхан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх А.Болортуяа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан референт П.Хулан нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар танилцуулав.

Төслийн үзэл баримтлалын талаар Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа, Ц.Мөнх-Оргил, Б.Дэлгэрсайхан, Б.Энх-Амгалан, Д.Ганбат, Ж.Сүхбаатар, Б.Энхбаяр нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Ш.Адъяаа, Б.Энхбаяр нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу эрх зүйн дүн шинжилгээ хийж дүгнэлт гаргуулах горимын санал гаргав.

Б.Энхбаяр: Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 7

Бүгд: 11
36.4 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Б.Энхбаяр: Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Ш.Цолмон, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Бат.Баярмаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан референт П.Хулан нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар танилцуулав.

Төслийн үзэл баримтлалын талаар Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, Ш.Адъяаа, Б.Энхбаяр нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг нар хариулж, тайлбар хийв.

Б.Энхбаяр: Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайхан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 22 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 28 минут үргэлжилж, ирвэл зохих 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр 16 цаг 22 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХУУЛЬ ЗҮЙН

БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.ЭНХБАЯР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 03 дугаар сарын 21-ний өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим
14 цаг 54 минут.

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Энхбаяр: Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2023 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулъя. Энхбаяр гишүүн ирсэн байна, Адъяаа гишүүн ирсэн байна, Алтанхуяг гишүүн ирсэн байна, Дэлгэрсайхан гишүүн ирсэн байна, Мөнхбаатар гишүүн ирсэн байна, Мөнх-Оргил гишүүн ирсэн байна, Ц.Мөнхцэцэг гишүүн ирсэн байна, Нямбаатар гишүүн ирсэн байна, Сүхбаатар гишүүн ирсэн байна, Б.Энх-Амгалан гишүүн хүрэлцэн ирсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Нэгдүгээрт Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл Засгийн газраас 2023 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудал. Хоёрдугаарт Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд Засгийн газраас 2023 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр өргөн мэдүүлсэн хуулийн төсөл хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ. Хэлэлцэх эсэх асуудлаар саналтай гишүүн хүн байна уу? Алга байна. хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.01.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Нэгдүгээрт Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх талаарх хэлэлцүүлгийг явуулъя. Төсөл санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Монгол Улсын Засгийн газрын гишүүн Хууль зүй, дотоод хэргийн сайд Хишгээгийн Нямбаатар танилцуулна. Нямбаатар сайдын микрофоныг өгье.

Х.Нямбаатар: Хууль зүйн байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас боловсруулсан Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бөгөөд хуулийн төслийн хэлэлцэх эсэхийг шийдвэрлүүлэхээр ХЗБХ-ны хуралдаанд танилцуулж байна. Хуулийн төсөлд дараах харилцааг зохицуулахаар тусгалаа.

Үүнд нэгдүгээрт санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага болох ФАТФ-н зөвлөмжид дурдсанчлан төрийн болон Засгийн газрын тэргүүнүүд, төрийн өндөр албан тушаалтнууд, шүүх болон цэргийн албан тушаалтнууд, төрийн өмчит корпорацуудын удирдах албан тушаалтнууд улс төрийн намын удирдах албан тушаалтнууд зэрэг төрийн томоохон чиг үүргийг хэрэгжүүлдэг эсхүл итгэмжлэгдсэн хүмүүсийг хамруулдаг

бөгөөд зөвлөмжийн 12-т улс орнуудыг улс төрд нөлөө бүхий этгээдэд эдгээрийг тодорхойлж хамруулахыг шаарддаг.

Тус зөвлөмжид нийцүүлэх зорилгоор Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан улс төрд нөлөө бүхий этгээдэд хамаарах субъектэд Улсын Их Хуралд суудал бүхий намын дарга түүнчлэн Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадгаас гадна танилцуулдаг байгууллагын дарга тэдгээрийн орлогч нарыг нэмж тусгалаа. Мөн эдгээр албан тушаалтан болон тэдгээрийн хамаарал бүхий этгээдийг нээлттэй тендер шалгаруулалтад оролцох боломжтой байсныг өөрчлөн бүх хэлбэрийн тендер шалгаруулалтад төрийн тендер шалгаруулалтад оролцуулахгүй байхаар тусгалаа.

2. Сингапур, Тайвань, Катар зэрэг зарим улсууд улс төрд нөлөө бүхий этгээд тэдгээрийн хамаарал бүхий этгээдийг өргөн хүрээнд тодорхойлж зарим үйл ажиллагааг хязгаарласан байна. Иймд олон улсын туршлагаас жишиг авч Монгол Улсын онцлогт нийцүүлэн улс төрд нөлөө бүхий зарим этгээд болох тэдний хамаарал бүхий этгээдэд зарим хязгаарлалтад хязгаарлалт, хориглолт тогтоох шаардлагатай гэж үзлээ. Тухайлбал улс төрд нөлөө бүхий зарим этгээдэд Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Монгол улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн Засаг даргын албан тушаал эрхэлж байгаа хүн байхаар тодорхойлсон бөгөөд тэдгээрт нөлөөлөх хамгийн ойрын хамаарал бүхий этгээдэд түүний эхнэр, нөхөр, хамтран амьдрагч, хүүхдийг хамааруулахаар тусгаж, эдгээрт төрөөс хэрэгжүүлэх, санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, арилжааны шинжтэй төсөл, хөтөлбөр эсхүл төрөөс олгох хөнгөлөлт, баталгаа, хандив, зээл хүртэгч, эсхүл тэдгээрийн гүйцэтгэж байгаа ААН-ийн нөлөө бүхий

хувьцаа, хөрөнгө эзэмшигч, хамтрагч байхыг хориглох нэмэлтийг тусгалаа.

Мөн улс төрд нөлөө бүхий зарим этгээд буюу Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн Засаг даргын эхнэр, нөхөр, хамтран амьдрагч, хүүхэд, төрийн албаны удирдах албан тушаал эрхлэх төрийн болон орон нутгийн өмчит компанийн компани, улсын үйлдвэрийн газрын гүйцэтгэх удирдлагад ажиллахыг хориглохоор зохицууллаа.

Түүнчлэн эдгээр хориглолт хязгаарлалтыг зөрчсөн этгээд болон эрх бүхий албан тушаалтанд хариуцлагыг хүлээлгэх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгаад байна. Хуулийн төсөлтэй холбогдуулан Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг боловсрууллаа. Хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Б.Энхбаяр: Нямбаатар сайдад баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Пүрэвжавын Сайнзориг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Шагдарсүрэнгийн Цолмон Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч, Мөнхдэлгэрийн Цолмон Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын шинжээч, Батмөнхийн Баярсайхан Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт дүн шинжилгээний хэлтсийн албаны дарга гэсэн албан тушаалтнууд оролцож байна.

Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан төсөл санаачлагчаас асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Асуулт эхлээд авна.

Сүхбаатар гишүүнээр тасаллаа. Адъяаа гишүүн асуултаа асууя.

Ш.Адъяаа: Энэ Засгийн газраас өргөн мэдүүлсэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байгаа. Миний бие Улсын Их Хурлын гишүүнийхээ бүрэн эрхийн хүрээнд энэ хуульд өөрчлөлт оруулахаар яг энэтэй адилхан ийм хуулийн төслийг өргөн барьж, ХЗБХ болон Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар дэмжигдсэн байгаа. Энэ хуулийн төсөлтэй нэгтгээд хэлэлцээд явахад би татгалзах зүйлгүй байна гэдгийг энд хэлье.

Өнөөдрийн энэ нийгэмд үүсээд байгаа нөхцөл байдал, сүүлийн 30 жилийн хугацаанд энэ төрд гарсан алдаа завхралын тодорхой хэсэг нь бол энэ улс төрд нөлөө бүхий этгээдүүд түүний хамаарал бүхий хүмүүс төрийн өмч хөрөнгөд янз бүрийн байдлаар гар дүрэх, улс төрд нөлөөлөл үзүүлж өөрийнхөө хамаарал бүхий хүмүүсийг төрийн өндөр албан тушаалд бусад төрийн гүйцэтгэх эрх мэдлийн албан тушаалд тавьж байсан энэ муу жишгийн энэ схемийг өнөөдөр таслахад Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн энэ хууль бол бас тодорхой хэмжээний шийдэл гаргахыг эрэлхийлсэн ийм зөв хуулийн төсөл гэдэг ийм бодолтой байна.

Өнөөдөр энэ хуулийн төслийг баталж гаргах нь бол өнөөдөр Монгол Улсын эрх ашиг, төрд итгэх итгэл, хууль дээдлэх зарчим, олон улсын өмнө Монгол Улсын хүлээсэн үүргийг биелүүлэхэд энэ Улсын Их Хурал энийг дэмжиж баталж гарах ёстой. Энэ дээр бас олон салаа ойлголттой ийм асуудлууд бас яригддаг. Энд Монгол Улсын Үндсэн хуулийн тухай үзэл баримтлалын тухай, хүний эрхийн тухай олон асуудал яригддаг хэдий ч өнөөдөр нийт улсын эрх ашиг, нийт олонхын эрх ашгийн төлөө энэ асуудал бол

яригдаад шийдэгдэх нь өнөөдөр Монгол Улсын Үндсэн хууль бусад хууль тогтоомжийг зөрчих ийм асуудал байхгүй гэдэг ийм бодолтой байдгаа энэ хэлэлцүүлэгт хэлье. Тэгээд Нямбаатар сайдаас нэг асуулт асууя. Энэ хууль зөрчсөн хүмүүст хариуцлага хүлээлгэх тухай энд дурдсан ямар хариуцлага хүлээлгэх юм бэ? Ер нь бол энэ хууль батлагдахаас өмнө ийм ашиг сонирхлын зөрчилтэй төрийн өндөр албан тушаалд Засгийн газарт томилогдсон тэдний хамаарал бүхий компаниуд энэ хуулийн үзэл баримтлал зөрчилдсөн ийм үйл ажиллагаа явуулдаг ийм юмнууд өнөөдөр хүртэл байгаа. Энэ хууль буцааж энд хэрэглэгдэх юм уу батлагдвал? Ийм хүмүүс байвал энд Засгийн газар ямар байр суурьтай байх вэ гэдэг талаар нэг тодруулгыг авъя гэсэн ийм бодолтой байна.

Б.Энхбаяр: Адъяаа гишүүний асуултад Нямбаатар сайд хариулъя.

Х.Нямбаатар: Яах вэ хуулийн төсөлд бид нар хариуцлага хүлээлгэх үндэслэл журмуудыг оруулж ирсэн. Тухайлбал хуулийн төсөлд туссанаар энэ албан Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, урьдчилан сэргийлэх, байгаа хуульд заасан энэ үндэслэл журмыг зөрчсөн албан тушаалтныг албан тушаалаас нь чөлөөлөх, огцруулах, эргүүлэн татах ийм үндэслэл болно гэдэг ийм зохицуулалт санкцыг оруулж ирсэн байгаа. Мөн дээр нь нэмээд хориглолт хязгаарлалтыг зөрчсөн этгээдийг 1 сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20-50 дахин, 20 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, байгуулсан гэрээ онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ, авсан зөвшөөрлийг хүчингүй болгох ийм зохицуулалтыг оруулж ирж байгаа.

Мөн дээр нь Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан зарим үйлдэл холбогдол нь дээрх Ашиг сонирхлын зөрчлийн хуулийг зөрчсөнөөс болж

үйлдсэн болох нь тогтоогдсон тохиолдолд Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан тодорхой төрлийн эрүүгийн хариуцлагуудыг хүлээхээр ингэж зохицуулалт оруулж ирсэн.

Б.Энхбаяр: Нямбаатар сайд гүйцээж хариулъя. Адъяаа гишүүний асуултад.

Х.Нямбаатар: Хуулийн төслийг дагуулаад дагаж мөрдөх журмын тухай хуулийг боловсруулж хамт өргөн мэдүүлсэн байгаа. Дагаж мөрдөх журмын тухай хуулиараа энэ харилцааг зохицуулаад явна. Мэдээж хэрэг ийм хориглолт хязгаарлалтуудыг шинээр тогтоож байгаа учраас тодорхой үйлчлэх хугацаа энэ тэрийг урьдчилж дагаж мөрдөх журмын хууль дээрээ зохицуулж өгч байгаа.

Б.Энхбаяр: Мөнх-Оргил гишүүн асуултаа асууя.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Засгийн газраас өргөн барьж байгаа хуулийн төслийг дэмжиж болох юм гэж бодож байгаа юм. Тэгэхдээ бас эргэлзээтэй юмнууд байгаад байгаа юм. Яах вэ би зүгээр нэг их Үндсэн хуулийн зөрчил рүү дагуулахгүй байх гэж бодож байна. Гэхдээ хууль санаачлагчаас бид нар асуугаад протоколд нэг тэмдэглүүлэх юм байгаа юм. Жишээ нь Үндсэн хуулийн энэ 2 дугаар бүлэг хүний эрх, эрх чөлөө, 14 дүгээр зүйл, 15, 16 дугаар зүйлийн 4 дээр ингээд биччихсэн байгаа байхгүй юу. Ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох эрхтэй гээд энэ үндсэн эрх л дээ. Тэгэхээр ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох эрх гэдэг энэ Үндсэн хуулиар олгогдсон эрхэд та бид таны өргөн барьж байгаа бид нар хэлэлцэх эсэхийг нь хэлэлцэж байгаа энэ хууль яаж уялдаж байна вэ? Ямар нэгэн байдлаар энэ Үндсэн хуулийн ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох зүйлтэй зөрчилдөх юм байна уу? Энэ хууль батлагдлаа гэхэд асуудал Цэц дээр очих нь ойлгомжтой байх гэж би бодож байна 14-ийн, 16.4-ийг зөрчсөн гээд. Тэгэхээр энэ

дээр бид нар нэг тал талдаа ойлголттой болчихмоор байгаа юм.

Ялгаварлан гадуурхахгүй заалт байгаа. Нөгөө энэ нийтлэг заалт байгаа шүү дээ 2 дугаар бүлгийн. Энэтэй яаж уялдах вэ? Би бол ялгаварлан гадуурхаж байна гэж үзэхгүй байгаа юм. Би тэгээд хэрэв шаардлагатай бол яагаад үзэхгүй байгаагаа би тайлбарлаж хэлье гэж бодож байна. Ажил мэргэжлээ чөлөөтэй сонгохтой үндсэн эрхтэй зөрчилдөхгүй байна гэж би жишээ нь үзэж байгаа юм. Гэхдээ хууль санаачлагчийн тайлбарыг сонсоод протоколд тэмдэглүүлчихье гэж бодож байна. Баярлалаа.

Б.Энхбаяр: Нямбаатар сайд.

Х.Нямбаатар: Миний нэг хугацааг 1 минутаар сунгаад өгч болох уу? Би нөгөө нэмэлт тайлбар дээр хэлье. Энэ нэгдүгээрт Монгол Улсын Үндсэн хуульд Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон тохиолдолд хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил албан тушаал хавсрахаас эхлээд Улсын Их Хурлын гишүүнд Үндсэн хуулийн хориглолт хязгаарлалтууд үйлчилж эхэлдэг.

Хоёрдугаарт Монгол Улсын Их Хурлын гишүүн бусад улс төрд нөлөө бүхий этгээдүүд тодорхой ажил албан тушаалд сонгогдож, томилогдохдоо нийт иргэн улсын ашиг сонирхлын төлөө ажиллахаа батлан тангараглаж, энэ албан тушаалд очиж ажиллахаа илэрхийлдэг ийм уламжлалтай. Би өнөөдөр бас энэ Байнгын хорооны хуралдаан дээр зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичгийг авчирсан юм. Энэ Богд хаант Монгол Улсын үед зарлигаар тогтоосон хууль зүйлийн бичигт хүртэл энэ улс төрд нөлөө бүхий этгээдүүдийг тодорхойлоод, тэдгээрийн хориглолт, хязгаарлалтуудыг одоогоос зуу гаруй жилийн өмнө тогтоогоод ирсэн. Ийм хууль цаазын уламжлалтай гэдгийг би хэлэх нь зөв байх.

Жишээлбэл энэ хууль зүйлийн бичигт аливаа албан тушаалын хэрэгт зайлуулбаас зохих нь нэгдүгээр зүйл. Нийслэлийн газар суух тэргүүн сайдаас доош бичээчээс дээш түшмэд болон олон хошуу шавийн албан яаманд эцэг, хөвгүүн, ач, авга, ах дүүг нэгэн яаманд суулгахгүй, нэгэн хошууны жинхэнэ албан тушаалд хавсран тавихгүй. Гадаад тушаалд гаргах болбоос гарах болбоос 5 зэрэг цагаан өмсөх төрөл жич эхийн төрөл, худ ургийн хүн, багш, шавийг хамт суулгахгүй. Цөм доод түшмэл зэрэг багыг байвал цөм доод түшмэл зэрэг багыг зайлуулна. Хэрэв хэрэг шүүхэд аливаа түшмэл, бичээч, заалдсан хүний дотор цагаан өмсөх, ураг удам хуучин захирсан дээд түшмэл, багш, шавь, жич хуучин өшөөтэй хүн буй аваас цөм би зайлагтун. Хэрэв зайлбаас зохих бөгөөд зайлахгүй болбоос тус хэргийг дагаж ял хэлэлцэхгүй гэх мэтээр ингээд хуульчилж ирсэн. Ашиг сонирхлын зөрчлийн уламжлалт ийм хууль цаазын бичгийн уламжлалтай гэдгийг би бас зориуд энэ Байнгын хорооны хуралдаан дээр хэлэхийг хүсэж байгаа юм.

Өнөөдөр бид нарын бас олон улсад бид нарын дагаж мөрдөж байгаа Авлигын эсрэг нэгдэн орсон конвенц болон Мөнгө угаах терроризмтой тэмцэх санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллагуудаас бидэнд өгч байгаа зөвлөмжөөр төрийн болон Засгийн газрын тэргүүнүүд төрийн өндөр албан тушаалтнуудад ийм нийтийн албаны ашиг сонирхлын зөрчлийн хязгаарлалтуудынхаа хүрээ хязгаарыг өргөжүүлээч гэдэг ийм зөвлөмжийг манайд ирүүлсэн. Энэ *domestic papers* дээр бид нар 12 дахь зөвлөмж дээр нь бид нарыг яг энэ хүрээ хязгаараа өргөжүүлэн зохицуулаач гэдэг ийм хязгаарлалтыг өгч байгаа. Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Ашиг сонирхлын тухай хууль дээр нээлттэй тендерээс бусад төрийн тендерүүдэд өөрийн хамаарал бүхий этгээдүүдээрээ тендер сонгон шалгаруулалт харьцуулалтын аргаар тендер сонгон шалгаруулалтад оролцож, тендер

авахгүй байхыг хуульчлаад бас нэлээн хэдэн жилийн нүүрийг үзээд явж байгаа.

Тэгэхээр бид нар энэ дээр нэмэх нь юуны нээлттэй тендерийг хязгаарлаж өгье гэж байгаа. Ер нь бол улс төрд бид нар шинэ соёлыг бий болгоё гээд Монгол Улсын Ерөнхий сайдаас энэ хуулийн төслийг боловсруулах санаачилгыг бидэнд гаргаж үүрэгжүүлсэн. Ерөнхий сайд өнгөрсөн 30 жилд бид нар мэдээлэлд ойр байгаа хүмүүс нь төрд байгаа мэдээллүүдийг ашиглаж төрөөс элдэв хөнгөлөлт дэмжлэгүүдийг авч ирлээ.../минут дуусав/

Б.Энхбаяр: Мөнх-Оргил гишүүн тодруулж асууя.

Ц.Мөнх-Оргил: Энэ дээр ийм л юм болоод байгаа юм л даа Нямбаатар сайдаа. Төрийн өндөр албан тушаал эрхэлж байгаа хүмүүст хязгаарлалт тогтоох тэр асуудал бол ойлгомжтой. Тэр бол өөрсдөө мэдээд төрийн өндөр албан тушаал ч гэдэг юм уу сонгууль энэ тэрт оролцоод эрхээ хязгаарлуулж байна шүү дээ, тодорхой хэмжээнд өндөр хариуцлага хүлээж байгаа учраас. Гэтэл бид нарын энэ батлах гээд байгаа хууль чинь тэр хүмүүсийн эрхийг хязгаарлах биш тэр хүмүүст хамааралтай хүмүүсийн өөрөөр хэлбэл тухайн хүнтэй хамааралтай буюу тэр өндөр албан тушаалтнаасаа гадна өөр хүмүүсийн эрхийг хязгаарлах гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр тэр утгаар нь бид нар яаж тайлбарлаж ярих юм бэ? Энийгээ нэгдүгээрт бодмоор байгаа юм. Жишээ нь ингээд энэ хуулийн төсөл дээр орж ирж байгаа санкц байна шүү дээ. Хуулийг зөрччихсөн бол нөгөө албан тушаалтанд нь хариуцлага тооцох гээд байгаа байхгүй юу. Нөгөө албан тушаалтан нь мэдээгүй байхад хамааралтай хүн нь ажил хийгээд явчихсан байх юм бол жишээ нь яах юм бэ? Хэнд нь санкц ноогдуулах юм гэдэг асуудал чинь аягүй чухал асуудал болчхоод байгаа байхгүй юу нэгдүгээрт. Хоёрдугаарт.../минут дуусав/

Б.Энхбаяр: Мөнх-Оргил гишүүн гүйцээгээд асууя.

Ц.Мөнх-Оргил: Хоёрдугаарт ерөөсөө үндсэн суурь зарчим нь ийм л дээ. Бид нар Үндсэн хуулиараа үндсэн эрх олгочихлоо. Гэхдээ ардчилсан нийгэмд нийтийн эрх ашиг ашигийн төлөө энэ үндсэн эрхүүдийг хуулиар хязгаарлаж болно тийм ээ. Тэгэхдээ нөгөө үндсэн эрхийнхээ үндсэн зарчимтай нь зөрчилдөхгүйгээр хязгаарлаж болно. Хязгаарлаж болохгүй 2, 3-хан л юм байгаа шүү дээ. Эрүүдэн шүүж болохгүй, албадан хөдөлмөрлүүлж болохгүй, эд нараас бусдыг нь бол хязгаарлаж болох байхгүй юу. Тэгэхээр энэ хүрээндээ л бид нар тайлбарлаж, ярьж, нийтийн эрх ашигийн төлөө ийм юм хийхээс өөр аргагүй энэ тэр гэдгээ тайлбарлаж ярихгүй бол нөгөө өндөр албан тушаал хашиж байгаа хүмүүст хязгаарлалт тогтоож байна гэж бид нар ойлгож болохгүй, цаад хүмүүст нь тогтоогоод байгаа байхгүй юу, гуравдагч этгээдэд.

Б.Энхбаяр: Нямбаатар сайд хариулъя.

Х.Нямбаатар: Би товчхон хариулъя. Энэ нэгдүгээрт бид нар олон улсын туршилага манай нэгдэн орсон конвенцуудын шаардлагыг биелүүлж энэ яг тэр улс төрд нөлөө бүхий этгээдийн хамгийн ойрын хамаарал бүхий этгээдүүдэд давхар ийм хориглолт хязгаарлалт тавихгүйгээс энэ болж ашиг сонирхлын зөрчилтэй олон үйлдлүүд өнгөрсөн хугацаа жилүүдэд хийгдсэн. Саяхан Энхбаяр гишүүний ахалж хийсэн Нийтийн сонсголоор, Хөгжлийн банкнаас ер нь хамгийн л их мэдээлэлд ойр бүх хүмүүс л энэ хөнгөлөлттэй зээл тусламжуудыг авсан гэдэг нь олон нийтэд ил боллоо шүү дээ. Тэгэхээр бид нар энэ олон улсын туршилагаар бол нэгдүгээрт энэ хүмүүстэй хамгийн ойрхон хүмүүс нь нэгдүгээрт ийм хязгаарлалтад орох ёстой.

Хоёрдугаарт тэр хүн улс төрд нэгэнт л улс төрд нөлөө бүхий этгээд болох гэж байгаа тохиолдолд хамгийн ойрын хамаарал бүхий хүмүүстэйгээ би улс төрд хамаарал бүхий улс төрд нөлөө бүхий этгээд болсноор чиний, миний бизнес дээр төртэй хамааралтай бүх юмнууд.../минут дуусав/

Б.Энхбаяр: Дэлгэрсайхан гишүүн асуулт асууя.

Б.Дэлгэрсайхан: Энэ өдрийн амар амгаланг айлтгая. Зүгээр энэ хуулийг бол би дэмжиж байна. Энэ ер нь бас сүүлийн үед ер нь хавтгайрсан л даа. Зүгээр энэ дээр нэг ганц тодруулж асуух гээд байгаа юм. Энд хүний сонгох, сонгогдох эрхийг хамааруулах гэж байгаа юм биш биз дээ? Жишээлбэл манайд ийм практик зөндөө бий шүү дээ. Ардчилсан намаас дүү нь нэр дэвшдэг, Ардын намаас ах нь ч юм уу, эгч нь ч юм уу нэр дэвшдэг энийг бас хамааруулах юм уу нэгдүгээрт?

Хоёрдугаарт энэ өмнө нь энэ хуулиар нэг баахан юм хаасан та нар мэдэж байгаа. Энэ үр хүүхэд, хамаатан садан, ах дүү нар нь янз бүрийн бизнес эрхэлж болохгүй барихгүй гээд л, гадаадад данс нээж болохгүй, хувьцаа авч болохгүй гээд. Энд нэг эргэж харах юм байгаа юм. Жишээлбэл хүний амьдрал баян ах дүү, төрөл садан олонтой хүмүүс зөндөө. Монголчууд их олуулаа шүү дээ жишээлбэл би гэхэд 8. 8 хүний 40 гаруй хүүхэд байна. 40, 50 ч байна бараг. Үгүй ээ тэгээд тэр хүүхдүүд чинь бидэнд хэлэхгүй энэ чинь юу дэлхий ертөнц хавтгай болчихсон хаана ч юу хийж болно гэдэг ийм юм байгаа учраас энд би юу орчхоод байгааг ингээд хэлээд байгаа вэ гэхээр зэрэг ялангуяа манай энэ ХЗБХ-ныхон энэ өмнөх алдааг засах ёстой.

Яагаад гэвэл зарим нь хэлэх, хэлэхгүй энэ бид мэдэхгүй байж байхад гэнэт гадна, дотнын хувьцаа аваад ч юм уу ингээд. Энийг яг нэг гэрт амьдарч байгаа гэдэг юм уу, насанд хүрсэн бол тэр нь яадаг юм уу, юу хамаарахгүй байдаг юм

уу. Ингэхгүй бол төрд ажиллаж болохгүй. Төрөөс ямар нэгэн дэмжлэг бизнес бас байхгүй. Үгүй ээ ямар нэг юм байхгүй. Энэ бол аягүй зөв. Харин хүн зүгээр мөрөөрөө ингээд гадуур гэр бүлээ ах дүү нараа тэжээх гээд ч юм уу ингээд бизнес хийхийг нь бас энэ хуулиар ингээд хориглочихсон байгааг бид эргэж харах нь зөв шүү. Энийг аягүй сайн бодоорой. Тэрнээс биш гишүүн болчихлоо, төрийн өндөр албанд орчихлоо гээд ингээд бүх юмыг нь хязгаарлаад, хориглоод ялангуяа манай хуулийн Хууль зүйн яамныхан бас энийг их анхаараарай. Тэр өмнө нь суусан тэр заалтуудыг Сайнзориг өөрөө мэдэж байгаа. Чи бараг оруулж ирэхэд тухайн үед байж л байсан. Тэр хуулийг бид нар 17 онд баталсан шиг санаж байна тийм ээ нэмэлт, өөрчлөлт оруулж байсан шүү дээ. Тэгээд оффишорын. Тэрнийг хамааруулаад нэг баахан юм баллаад, нэмээд тавьчихсан учраас энэ дээр бас аягүй их сүүлд нь нөгөө хүн өөрөө мэдэхгүй байж байгаад хэрэгт орчих юм байна гэж би эргэж зүгээр бодоод байгаа юм. Тэрийг та нар эргэж хараарай.

Тэрнээс биш энэ төрөөс давуу байдлаа ашиглаад л энэ ах дүү, хамаатан саднаараа нийлээд л төрийг цөлмөөд юм уу эсвэл хүний боловсрох боловсрол олгох тэр боломж энэ төрд давуу эрх эдлээд байгаа энэ тэр бол үнэхээр нийгмийг бүхмидуулж байгаа, яалт ч үгүй энэ бол зөв арга хэмжээ л гэж би бодож байгаа. Хэн мэдээлэлтэй нь авдаг энэ тэр, илүү боломж хулгайлдаг авдаг энэ тэрийг бол хаах нь зөв л гэж бодож байна. Баярлалаа.

Б.Энхбаяр: Сайнзориг дарга хариулъя, 3 номерын микрофон.

П.Сайнзориг: Дэлгэрсайхан гишүүний асуултад хариулъя. Би оршил болон суурь мэдээлэл өгөхгүйгээр хариулаад явчихъя. 2 асуулт үндсэн асуулаа. Түрүүн Нямбаатар сайд бас ерөнхий үзэл санааг бас хэлэлцсэн учраас би давтаж цаг алдахгүйгээр явъя. Ер нь сүүлийн асуултаас тэр оффишортой

оффишорын өөрчлөлттэй холбоотойгоор та бас асууж байна. Тухайн үедээ бас ХЗБХ-ны дарга буюу дэд сайд байхдаа бас Энхбаяр гишүүн бас энэ хууль дээр бас нэлээн ажиллаж орж ирж байсан. Улсын Их Хурал дээр бид хэд яах вэ зүгээр боловсруулсан хуулийн төслөө бол бас тодорхой хэмжээнд хүртэл өөрчлүүлсэн. Өөрөөр хэлэх юм бол хамрах хүрээг бас хэт хавтгайтай болсон нь үнэн. Таны хэлж байгаа яг үнэн байгаа.

Бид бас тодорхой хянаж чадах хүрээндээ энэнээсээ үүсэх үр дагавар дээр хариуцлага тооцох гэдэг юм уу, залруулж чадах хүрээндээ бас уг асуудлыг бас тухайн үедээ 17 онд оруулж ирсэн боловч бас хамаарал бүхий этгээд гээд маш өргөн хүрээнд бас оруулсан нь өнөөдрийн юу гэдэг юм хянаж болохгүй гэдэг юм уу, яг энэ хуулийн бас зохицуулалт чинь амьдралд нийцэхгүй байна шүү дээ гэдэг шүүмжлэл ер нь бас ороход нөлөөлсөн гэдэг зүйлийг бас танд хэлэх нь зөв байх. Бид нар бас энэ хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлж байгаад тодорхой түвшинд нь бас холбогдох бас өөрчлөлтүүдийг сайжруулж оруулж ирэх асуудлыг анхааръя гэдэг зүйлийг нэгдүгээрт танд хэлмээр байна.

Хоёрдугаарт ерөнхийдөө яг энэ өөрчлөлтүүд нь бол үндсэндээ аж ахуй үйл ажиллагаа эрхлэлттэй холбоотой хориглолт угаасаа байсан. Энэ дээр бол зүгээр зарим этгээдүүд орхигдсон байсныг нэмсэн байгаа. Түрүүн Нямбаатар сайд бас танилцуулгатай хийсэн. Улсын Их Хуралд ажлаа тайлагнадаг танилцуулдаг гээд ерөнхийдөө 2 зарчим байгаад байгаа. Тэгэхээр энэ байгууллагуудын орлогч нар бол орж ирж байгаа. Жишээ нь ингээд улс төрд нөлөө бүхий этгээдэд ерөнхий прокурорын орлогч ч байдаг юм уу эсвэл аудитын орлогч нар ч гэдэг юм уу ингээд ордоггүй ийм зүйлүүд байсан. Энийг бид нар бас хамруулж орж ирж байгаа.

Хоёрдугаарт яах вэ зүгээр зарим талаараа энэ компаниуд нь төрийн

тендерт бас оролцох хязгаарыг нь бид нар бас байсныг нь нээж өгч байгаа юм. Өөрөөр хэлэх юм бол бараг Монгол Улсын бүх иргэн 1072 хувьцаатай. Энэ 1072 хувьцааг гаргасан компани нь төрийн үйл ажиллагааны худалдан авах ажиллагаанд бараг оролцох боломжгүй байгаа юм хувь гэгчихсэн байгаа. Хувь хөрөнгө эзэмшигч гээд. Энийг бид нар бас тодруулж нөлөө бүхий хувьцаа эзэмшигч гэж бас энэ 5 хувиас дээшээ хувьцаа эзэмшигч нь улс төрд нөлөө бүхий байгаа бол тухайн компани бас төрийн тендерт орж болохгүй шүү гэдэг энэ хязгаарлалтыг бас ойлгомжтой болж өгч байгаа. Шинээр яг орж ирж байгаа түрүүн Мөнх-Оргил гишүүний бас асуугаад байгаа буюу улс төрд нөлөө бүхий зарим этгээд гэдэгт нь илүү их чангаруулсан хориглолтыг орж ирж байгаа юм. Энэ дээр бол Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүд, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга гэсэн албан тушаал дээр л зөвхөн тэдгээрийн хамгийн ойрын хүн буюу эхнэр, нөхөр, хамтран амьдрагч, төрсөн болон дагавар үрчлэн авсан хүүхдийг л бид хэд яг энэ хамруулж байгаа.

Таны яг асууж байгаа тэр төрд ажиллаж болно. Тэгэхдээ төрд ямар албан тушаал дээр ажиллуулахгүй гэхээр зөвхөн удирдах албан тушаал эсвэл төрийн өмчит компанийг удирдах албан тушаал дээр бол эдгээр хүмүүсийн яг саяын дурдсан хүмүүс бол ажиллаж болохгүй. Нөгөө талдаа төрийн өндөр албан тушаалыг бас хашиж болохгүй гэсэн үг. Тэгэхээр яг таны ярьж байгаа саяын одоо, манай бас нөхцөл байдалд гардаг практикаар бол нэг гэр бүлийн гэдэг юм уу гишүүдээс Улсын Их Хуралд хоёулаа орж ирэх ч гэдэг юм уу боломж ер нь байхгүй л гэсэн шууд хариултыг бас танд хэлэх нь зүйтэй байх.

Б.Энхбаяр: Дэлгэрсайхан гишүүн тодруулж асууя.

Б.Дэлгэрсайхан: Би тэрийг л асуусан шүү дээ. Би ийм юм асуугаад

байхгүй юу Сайнзоригоо. Энэ хүний сонгох, сонгогдох эрхэд халдаад байгаа юм биш үү? Ухаандаа энэ практикт зөндөө л байдаг шүү дээ. Тийм учраас энийг бас сайн тайлбарлахгүй бол наадах чинь их буруу зөрүү. Ялангуяа Ардчилсан намаас нэг ах нь ч байдаг юм уу, Ардын намаас дүү нь ч байдаг юм уу ингээд сонгогдоно гээд нам нь нэр дэвшүүлчихсэн байхаар наадах чинь аягүй тийм юу болчихож байгаа байхгүй юу. Хэрүүл болж эхэлнэ шүү дээ. Тийм. Тэгээд энийг асуугаад байгаа юм шүү нэгдүгээрт.

Хоёрдугаарт бол энэ дээрээ давхар ХЗБХ-ны дарга өөрөө дэд сайд байхдаа энэ өмнөх хуулийг яасан юм байна, их өргөжүүлж оруулж ирсэн юм байна. Тэгээд энийг зүгээр засах нь хожимдоо олон хүмүүст хэрэг болох байх. Яагаад вэ гэхээр одоогийн залуучууд гадаад, дотоодод боловсрол эзэмшээд, гаднын том, том компаниудад ажилд ордог.

Б.Энхбаяр: Нямбаатар сайд хариулъя.

Х.Нямбаатар: Тэр эхний 17 онд орсон нэмэлт, өөрчлөлтөөр бид нар тэр зарим улсуудын жагсаалтыг гаргахад энэ тэр дээр алдаа гаргасан зүйлүүд байгаа. Энийг Засгийн газрын тогтоолын төслөөр бид нар бас засахаар энэ хууль батлагдахтай холбоотой зэрэг арга хэмжээ авна гэдгийг хэлье. Хоёрдугаарт Улсын Их Хурлын гишүүнээр ах, дүү 2 зэрэг нэр дэвших бол тэр хүмүүсийн сонгогдох эрх учраас энэ эрхэд бид нар хязгаарлалт тогтоож болохгүй. Хоёрдугаарт тэр сонголтыг хийж байгаа ард түмний мандатыг бид нар бас хүндэтгэх ёстой. Энэ бол бас Үндсэн хуулийн зөрчил рүү явах учраас хэлэлцүүлгийн явцад энийг бүр тэр тодотгож өгье хэдүүлээ. Энийг хэлэлцэх эсэхээ шийдчихээд, дараа нь хэлэлцүүлгийн явцад энэ дээр анхааръя.

Б.Энхбаяр: Б.Энх-Амгалан гишүүн асуултаа асууя.

Б.Энх-Амгалан: Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлоос сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг бол ойлгож байгаа, дэмжиж байгаа. Тэгээд энэ дээр энэ хуулийн гол зохицуулах зүйл бол Төрийн албаны тухай хуулийн 17.1 буюу төрийн өндөр албан тушаалтан мөн хуулийн 18.1.1 буюу төрийн захиргааны тэргүүн түшмэлийн ангилалд багтсан албан тушаалтан, Засгийн газрын агентлагийн дарга, Их Хуралд суудал авсан намын дарга, тэгээд энэ агентлагийн орлогч дарга гээд энэ хүмүүс орох юм байна. Тэгээд энэ хүмүүс ингээд харахаар улс төрд нөлөө бүхий этгээдээс иргэдийн сурч боловсрох эрхийг хамгаалах үүднээс энэ нөлөө бүхий этгээдийн нөлөөллөөс ангид, тэгш бүтээмжтэй болгоно гээд. Ингээд хүүхэд нь ямар ч байсан сурч болохгүй юм байна. Тэр яаж ямар ч онц сурдаг байгаад нэмэр алга. Энэ бол нөгөө хэнийг ч боловсрол мэдлэг, нийгмийн гарал үүсээр ялгаварлан гадуурхаж болохгүй гэдэг Үндсэн хуулийн зарчимд нийцэж байна уу, үгүй юу?

Хоёрдугаарх нь энэ 16.4 Үндсэн хуулийн 16.4-д ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох ийм эрхтэй байгаа. Тэгэхээр энэ хүн ямар ч байсан төрийн болон орон нутгийн өмчит компани, улсын үйлдвэрийн газарт удирдах ажил хийж болохгүй юм байна. Ямар ч мундаг чадвартай байгаад тэр бол болохгүй л гэх юм байна.

Гуравдугаарт нь бол ингээд төрөөс хэрэгжүүлж байгаа энэ хөрөнгө оруулалт, санхүүжилт, арилжааны төсөл хөтөлбөр, хөнгөлөлт баталгаа, хандив зээл энэ юманд ерөөсөө орж болохгүй юм байна. Дээр нь нэг 5 хувийн хувьцаа л эзэмшиж байгаа бол тэгээд л тэр компани нь бол ямар ч төсөл хөтөлбөрт орох бололцоогүй юм байна. Тэгээд хамрах хүрээ нь ингээд харахаар зэрэг тэр хүний эхнэр, нөхөр, хамтран амьдарч байгаа хүн, төрсөн хүүхэд,

дагавар хүүхэд, үрчилж авсан хүүхэд гээд ингээд явчхаж байна л даа. Тэгээд энэ чинь Улсын Их Хурлын гишүүн бол өөрөө тангараг өргөж байгаа, төрийн албан хаагч өөрөө төрийн тангараг, тангараг өргөж байгаа. Тэгээд энэ хүмүүс чинь бол эрхээ хязгаарлуулж байгаа шүү дээ. Давхар ажил үйлчилгээ эрхлэхгүй, бизнес хийхгүй, тийм ээ. Төрийн болон төрийн бус байгууллагуудад давхар ажиллахгүй энэ тэр гэсэн.

Тэгээд эдний эхнэр, нөхөр, тэгээд хүүхэд, тэгээд хамтран амьдардаг хүн дагавар хүүхэд гээд бүх юм нь ингэчихээр энэ хүнтэй суусны хохь болж байна уу, яаж байна вэ? Ингэж цаашаа явахад хэр нийцэж байна вэ? Тэгээд энэ Засгийн газрын агентлагийн дарга энэ нэг намын дарга, энэ нэг агентлагийн орлогч дарга, төрийн захиргааны энэ тэргүүн түшмэл гэдэг чинь ямар юмаараа хүүхдээ сургах юм бэ? Нэг гадаадад сурах гээд тэтгэмж авах гэдэг чи болохгүй гээд хуулиар хориотой байж байдаг. Нөгөө хүүхэд нь оноо нь тэр IELTS оноо нь хүрээд идэвхтэй сайн сураад байдаг. Тэгээд аав нь ажил албан тушаал эрхэлж байгаагийнхаа төлөө тэр хүүхэд ийм юмнаас хоцорч байвал яах вэ? Тэр ажил албан тушаалд тэнцэх мэргэжил эзэмшиж орж ирчхээд тэр ажил албан тушаалаа хийж чадахгүй ийм байдалд орвол яах вэ? Энэ өөрөө Үндсэн хуулийн зөрчил мөн үү биш үү? Энийг маань та нар яаж харж байна вэ? Энэ талаас нь нэг тайлбарлаадхаач.

Б.Энхбаяр: Нямбаатар сайд хариулъя.

Х.Нямбаатар: Нэгдүгээрт Энх-Амгалан сайд, гишүүний асуултад хариулахад зөвхөн улс төрд нөлөө бүхий этгээдүүд буюу Ерөнхийлөгч, Засгийн газрын гишүүн, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын гишүүн гэсэн ийм тодорхой албан тушаалтнуудын хүүхдэд энэ хязгаарлалт хамаарч байгаа юм. Бусад тэр агентлагийн орлогч дарга, агентлагийн дарга нарын хүүхдүүдийн тухайд энэ эрх

нь яг тэр үндсэн сонгон шалгаруулалтынхаа журмаар явах тэр боломж нь нээлттэй гэж ойлгож болно.

Хоёрдугаарт Энх-Амгалан гишүүнээ би нэг зүйлийг л хэлэх гэсэн юм. Ерөнхий сайдын барьж байгаа бодлого нь бид нар энэ өнгөрсөн 30 жилд дандаа ийм мэдээлэл давуу тал эзэмшиж байсан, албан тушаал дээр байсан хүмүүс нь бүх боломжуудыг түрүүлж хүртээд ийм хэвшил болчихлоо. Бусдад боломжийг дандаа олгохгүй явлаа. Жишээлбэл бидний үед ч гэсэн дарга цэрэг нарын хүүхдүүд дандаа л гадаадад сургууль төгссөн байгаа. Өөрөөр хэлбэл энэ адил боломж бид нарт байгаагүй гэж товчхондоо хэлэх гээд байгаа юм. Тэгэхээр цаашид бусад хүмүүсийн тухайд бид нар энэ боломжийг үлдээдэг байя.

Сая тэр Хөгжлийн банктэй холбоотой асуудал харлаа. Бид нар яагаад 5 хувийн босго тавьсан бэ гэхээр 1990 оны өмч хувьчлалаар ягаан, цэнхэр тасалбараар хүн болгон тодорхой компаниудын хувьцаа эзэмшсэн. Тэр тохиолдолд 5 хувьд хүрэхгүй байгаа учраас тэр хүмүүсийн тухайд бусад компаниудад нь хязгаарлалт тогтоохгүй байя гээд байгаа юм. Хамгийн гол агуулга нь та улс төрд нөлөө бүхий этгээд болохынхоо өмнө л сонголтоо хийнэ. Хэрэв та улс төрд нөлөө бүхий этгээд болбол таны ойрын хамаарал бүхий этгээдүүд чинь энэ хязгаарлалтад орох нь гэдгээ л сонгох гээд байгаа юм. Тэрнээс биш тэр хүмүүсийг давхар хязгаарлалт тогтоож байгаа гэхээсээ илүүтэй энэ хамгийн ойрын эхнэр, нөхөр, хүүхэд дээр хоорондоо ийм асуудлуудаа яриад хэрэв би ингээд улс төрд нөлөө бүхий этгээд болбол та бүхэн ийм, ийм төртэй хамааралтай элдэв төрлийн хөнгөлөлт, бизнес хийж болохгүй нь. Энийгээ хэдүүлээ гэр бүлээрээ сонголтоо хийж байгаад ярья л гэж байгаа юм.

Тэрнээс биш Дэлгэрсайхан гишүүний түрүүчийн бас хэлж байгаа шиг бүр тийм хамаарал холын

хамааралтай нөхдүүд энэ тэрийг төрийн тендерийн хязгаарлалт тогтоогоогүй шүү дээ. Зөвхөн Ерөнхийлөгч, Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн дарга гэсэн ийм хүмүүсийн тухайд л төрийн энэ нээлттэй тендер сонгон шалгаруулалтад хязгаарлалт тавьж байгаа юм. Бусад хүмүүсийн бизнес хийх эрхийг аль болох бид нар хөндөхгүй байя л гэсэн санаа хэлж байгаа юм.

Б.Энхбаяр: Энх-Амгалан гишүүн тодруулж асууя.

Б.Энх-Амгалан: Энэ төрийн албаны удирдах албан тушаал гэдэгт төрийн албаны тухай хуулийн 17.1-д заасан төрийн өндөр албан тушаалтан гээд таны саяын хэлж байгаа Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Их Хурлын гишүүн, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтан, мөн хуулийн 18.1-д заасан төрийн захиргааны тэргүүн түшмэлийн ангилалд багтах албан тушаалтан, Засгийн газрын 20.2 дахь хэсгийн Засгийн газрын агентлагийн дарга, Их Хуралд суудал бүхий намын дарга гээд ингээд байж л байна л даа. Тэгээд сая хариулахдаа бол прокурорын орлогч гээд ингээд орлогч дарга нар бас орох юм л гэж байна. Зүгээр би санааг нь бол ойлгож байна. Гэхдээ энэ маань цаашидаа Монгол төрийн чадамжийг буулгах вий дээ. Энэ хүмүүс чинь ингээд төрд ажиллах хүн олдохоо байчих вий дээ. Монгол төрийн төлөө зүтгээд үнэнчээр зүтгээд тангараг өргөөд зүтгээд, тэгээд эргээд энэ үр удамд нь хохиролтой юм байна, тэрэнд дорвол холхон байж байя гээд ингээд төрд зүтгэх үнэнч хүмүүс чинь ховор болчих вий дээ гэдэг талаас нь анхаараарай. Яагаад гэвэл тендерт ордог албан тушаалтан олдохоо байсан гэж ярьж байна лээ шүү. Энийг л бол.../минут дуусав/

Б.Энхбаяр: Үг хэллээ. Ганбат гишүүн асуултаа асууя.

Д.Ганбат: Ингээд л нэг сонгууль ойртож байгаа юм байна л даа. Тэгээд нэг ээлжит л нэг попорсон хуулиа л батлах гээд л зүтгүүлж байгаа юм байна гэж ойлгож байна. Тэгээд яг энэ хууль батлагдаад, тэгээд ямар, ямар үр дүн гарах юм бэ? Хэчнээн хүн ажлаас чөлөөлөгдөхөөр байна вэ, бас судалгаа хийсэн л байлгүй. Тэгээд л бүгдээрээ л дэмжээд байгаа юм шиг байна. Надад миний хувьд бол ямар ч падгүй хууль байна. Яагаад вэ гэхээр миний ах дүү нар олуулаа л даа. Хэн нь ч төрийн албанд ажилладаггүй, хэн нь ч тендер авдаггүй. Тийм болохоор ерөөсөө пад ч алга мань мэтэд бол. Ер нь тэгээд Ардчилсан нам үнэт зүйл үзэл баримтлалдаа ийм үнэнч байгаа хүмүүс бол хаана л бол хаана шахагдаж явж байдаг. Тэрэн дээр бол нэг их онц юм яриад байх юм алга. Эргээд л ээлжит ард түмнээ хуурах үйл ажиллагаагаа явуулж байна. Тэгээд энийгээ дагуулаад баахан хүн хэлмэгдэх юм байна. Тэгээд наад юмаа хийх гэж байгаа бол гүйцэд хий, хамгийн самардаг улсууд чинь бол бас үүнээс гадна юу байгаа шүү дээ. Нөгөө ямар харьцаатай улс гэдэг билээ. Нөгөө нууц амрагууд чинь бол маш том, том албан тушаал эзэлж байгаа шүү дээ, хашиж байгаа. Тэрийг хэвлэлээр өдөр шөнө өдөр шөнөгүй л бичиж байна. Тэрийгээ оруулах юм уу яах юм бэ? Тэгээд наадах чинь цаашидаа бол бараг онигоо болно ингэж явсаар байгаад. Тэр тал руугаа явж байна.

Тэгээд нөгөө талаар бас юу байна. Юу гэххэв. Тайвань, Катар гэсэн улсууд байдаг гэххэв үү? Тийм. Сингапур гээд. Сингапур гэж улс байдаг байх. Нөгөөдүүл нь бас ингэж байж хоригт оров. Наадхаа сайн судалгаатай бичээрэй, яриарай.

Нөгөө талаар бол Засгийн газарт хэр олон хамаатан саднууд байна вэ? Энэ талаар юу гэж хариулах вэ? Тэр хүмүүс яах юм бэ? Тэгээд энэ хуульд хамрагдах юм уу, үгүй юм уу? Хамгийн эрх мэдэлтэй улс бол Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн гээд давхар дээлтэй л энэ улсууд байгаа шүү дээ. Энэ дээр юу гэж бодож

байна вэ? Яах вэ би чуулган дээр хэлье, битгий яар тийм. Би бас таны юу ярихыг бас сонсмоор байна шүү дээ. Тийм. Ийм, ийм юм байна. Бас ахиад л ээлжит нөгөө нэг бид нар нэг хүүхдийн мөнгийг өгч байсан даа Ардчилсан нам. Тэгээд тэрний эсрэг ч гэдэг юм уу, тэрэнтэй дүйцэхүйц хэмжээний нөгөө шинэ суусан гэр бүлд билүү 500000 төгрөг өгье гээд л. Тэгээд нөгөө 2 чинь суугаад л, дараа нь салаад л ингээд л баахан юм болсон. Энэ баахан дарга сайд нар ингээд салж сарних вий. Тийм юм гарах уу үгүй юу? Судалгаа энэ тэр байгаа юу үгүй юу? Нөгөө улсууд чинь ажил төрөл энээ тэрээ гэдэг. Баахан Засгийн газрын хүмүүс салж нийлээд л ингээд эхлэх үү яах вэ?

Тэгээд баахан энд Ардын намын Улсын Их Хурлын гишүүд нь нийлээд, салаад л гэр бүл нь салж сарниад л ингэх үү? Энэ Ардын намынхныг дагаж гүйдэг бас нэг манай хэд ч гэсэн байна л даа. Тэр улсууд чинь байнга тендер авдаг. Тэрийг нь өгдөг найруулдаг ийм юмыг бүгдээрээ л мэднэ. Маньд бол ёстой пад алга наад юм чинь бол. Тэгээд бас л ахиад тийм үр дагавар гарах уу яах вэ? Сайн үр дагавар нь юу байна, муу үр дагавар нь юу байна вэ? Сайн үр дагавраа л яриад байх шиг байх юм. Муу үр дагавар нь юу байна вэ? Ингээд нөгөө сайд нар маань эндээ ажлаа хийх гэдэг. Гэр оронд нь хүнд хэцүү байдал үүсдэг. Энэ Улсын Их Хурлын гишүүд чинь бас баахан онигооны эзэд болдог. Тэгээд яах вэ сонгуулийн дараа бас дахиад л энэ хуулиа тэгээд болиулдаг. Тэгээд нөгөө нэг Үндсэн хуулийн өмнө иргэн болгон хүн болгон адил тэгш байна энэ тэрээ гээд л баахан юм заадаг. Уул нь наадах чинь ёс суртахууны хувиар л ингээд зохицуулагдчих ёстой юм шүү дээ. Гэтэл ингэж хууль оруулж ирээд ингэчих байна уу. Өөрсдөө л нэг сайхан аятайхан байчихмаар байх юм. Гэтэл ийм юм байхгүй байна л даа.

Б.Энхбаяр: Нямбаатар сайд хариулъя.

Х.Нямбаатар: Би Ганбат гишүүний асуултад товчхон хариулъя гэж бодож байна. Нэгдүгээрт энэ Монгол Улсын Засгийн газраас авлигатай тэмцэх чиглэлээр хэд хэдэн хуулийн төслийг боловсруулах ийм ажлууд хийгдэж байгаа. Тухайлбал Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийг Их Хуралд өргөн барьсан. Цаашид тэр ямар бизнес хийх юм, ямар бизнес хийхгүй юм. Төрийн хийж байгаа бизнесийг хэн удирдах юм гэдгийг бас тодорхой болгож өгье. Энэ өнгөрсөн 30 жилийнхээ алдаа завхралд дүгнэлт хийе. Энэ мэдээлэлд ойр, эрх мэдэлд ойр байгаа хүмүүс нь төрийн бүх боломжийг иргэдийнхээ урдуур орж авдаг юмыг л хязгаарлаж зогсооё гэж байгаа юм. Энийг бол би попролт гэж үзэхгүй байна Ганбат гишүүнээ.

Хоёрдугаарт та сая нэлээн ноцтой юм ярилаа. Танай Их Хурлын Ардчилсан намын бүлгийн хэн гэдэг гишүүнд хэн гэдэг сайд дарга нар тендер өгсөн юм бэ? Та гэмт хэргийг нуун дарагдуулж байгаа юм биш биз? Сая та аягүй тодорхой тийм мэдээлэл байгаа би яривал ярина гэж байх шиг байна. Би таныг Авлигатай тэмцэх газар яг энэ чиглэлийнхээ мэдээллийг өгөхгүй бол та Улсын Их Хурлын гишүүн хүнийхээ хувьд гэмт хэргийг нуун дарагдуулсан ийм үйлдэл болно шүү.

Хоёрдугаарт энэ өнөөдрийн байдлаар бид нар яг энэ хууль батлагдахаар хэчнээн хүн төрийн албанаас халагдаж чөлөөлөгдөх тийм тооцоо судалгааг гаргаагүй байна. Яагаад гэхээр өнөөдөр ХОМ бөглөдөг хүмүүсийн тоо маш их. Тэгэхээр энэ хууль батлагдсанаар ХОМ гаргадаг ХАСХОМ бөглөдөг бүх хүмүүс яг энэ хуулийн хориглолт хязгаарлалтын дагуу өөрөө мэдүүлэх үндсэн үүрэгтэй. Энэ үүрэг хэрэгжүүлээгүй тохиолдолд Нийтийн албанд энэ ашиг сонирхлын төслийн тухай хууль маань хүчин төгөлдөр араас нь үйлчилж, тэр хариуцлага, албан тушаалаас чөлөөлөх энэ тэр асуудлууд тухайн үед яригдах ийм зохицуулалттай.

Тийм ч учраас дагаж мөрдөх журмын хууль хийсэн.

Тэгэхээр зүгээр би Ганбат гишүүнийг бас нэг юмыг би яг хичээнгүйлэн хүсэж байна. Хэдүүлээ энэ нэг яг ингээд нэг гараанаас асуудлаа яг иргэд, аж ахуйн нэгжүүддээ боломж олгодог больё. Тендерт дайрч ороод өөрсдийнхөө компаниудаар авдаг тэр соёлыг бүрмөсөн устгая л гэдэг л ийм агуулгаар орж ирж байгаа юм. Энийг би буруу зүйл гэж бодохгүй байна. Тэгээд таны ярьж байгаа 3 үг тутмын 2 нь дандаа ийм улс төржсөн өнгө аястай юм ярих юм. Би өнөөдөр бол тантай тийм юм яримааргүй байна. Би яривал ярина.

Б.Энхбаяр: Ганбат гишүүн тодруулж асууя.

Д.Ганбат: Улс төржсөн өнгөтэй гээд та хэлчих шиг боллоо тийм ээ. Угаасаа л бүх асуудал улс төрийн өнгөнөөс л явна шүү дээ. Энэ чинь тийм байж байж энэ чинь 2 нам байгаа юм шиг, олон намын системтэй юм шиг харагдана шүү дээ. Тэгэхгүй бол тэгээд нэг л намын систем шиг ингээж харагдана тэр талаар бас та зөв ойлголттой болох хэрэгтэй.

Тэгээд үр дүн нь ямар байх юм бэ, судалгаа хийсэн юм уу? Зүгээр л яах ийхийг нь мэдэхгүй байна гэсэн ийм юм байгаа юм уу? Яг тэгээд энэ гадна, дотно байгаа өөрсдөө бас өөрийнхөө боломжуудыг хаалгасан улсуудад ийм боломж нь ихсэх үү гэсэн л ийм л зүйл асуугаад байна л даа. Та бол ихэснэ л гээд байх шиг байна. Тэгвэл тийм байгаа бол сайн байна. Тэгээд л батлаад л явъя, үзье, харъя. Ингээд мэдээж хэрэг та нар батална гээд шийдчихсэн бол баталж л таарах байх. Муу үр дагавар нь ямар үр дагавар байна вэ гэдгийг чинь бас тодруулаад байна л даа. Тийм. Сайхан нэр доор хийсэн юм.../минут дуусав/

Б.Энхбаяр: Нямбаатар сайд нэмж хариулъя.

Х.Нямбаатар: Энэ санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллагаас бидэнд зөвлөмж ирүүлсэн юм Ганбат даргаа. Би түрүүн танилцуулгадаа уншсан шүү дээ. ФАТФ-аас ирүүлсэн зөвлөмжийн хүрээнд бид нарыг энэ улс төрд нөлөө бүхий этгээдүүдийг хүрээ хязгаарыг өргөжүүлээч гэдэг нэгдүгээрт шаардлага тавьсан.

Хоёрдугаарт энэ зөвлөмжийг бид нар хэрэгжүүлж байна. Дээр нь та түрүүн асууж байна лээ. Энэ Сингапур, Тайвань зэрэг улсуудыг яагаад жишээ авч байгаа юм бэ гэсэн асуудал ярьж байгаа юм. Өнөөдөр авлигын төсөөллийн индексийг гаргадаг Транспэрэнси интернэйшнл ОУБ-ын судалгаагаар хамгийн авлига багатай орнуудын нэгд яах аргагүй Сингапур улс байгаа. Энд энэ хязгаарлалт хориглолтуудыг нийтийн албан тушаалтнууддаа маш тодорхой тавиад өгчихсөн ийм хязгаарлалт байдаг. Тэгэхээр бид нар цаашид нийтийн албан тушаалтнуудынхаа энэ хориглолт хязгаарлалтыг тогтооё, энэ хүмүүс түүний хамаарал бүхий этгээдүүд төрөөс элдэв тэр хөнгөлөлттэй зээл ч авахгүй байя, нээлттэй сонгон шалгаруулалт.../минут дуусав/

Б.Энхбаяр: Сүхбаатар гишүүн асуултаа асууя.

Ж.Сүхбаатар: Би нөгөө Засгийн газрын гишүүн учраас асуулт гэхээс илүүтэй бас энэ дээр нэг тодотгол хэрэг хийх хэрэгтэй байгаад байгаа юм. Нийтийн албанд болон Нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль гэдгийг 2008-аас 12 оны үеийн парламент буюу миний хувьд бол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга байх үедээ Тэмүүжин гишүүн эд нартай бол нийлж санаачилж батлуулж байсан. Тухайн үед хүмүүс попорсон хууль энэ хэрэгжихгүй хууль гэж ярьж шүүмжилж байсан юм бий.

Гэхдээ өнгөрсөн он жилүүдэд харахад бол энэ хуулийг баримталж хүмүүс ашиг сонирхлын зөрчил ярьдаг болсон, хэмжүүртэй болсон, шалгууртай болсон. Тэгэхээр энэ conflict of interest гэдэг энэ юм бол үнэхээр төрийг энэ авлигажсан энэ бусад улс орон дээр ч гэсэн өндөр хөгжсөн улс орон дээр авлигаас яагаад сэргийлээд байна вэ гэхээр энэ хууль байж ёс зүйн асуудлууд бусад асуудлууд их тийм зөв зүйтэй хүрээ хязгаар нь тодорхой болж ирээд байгаа юм. Тэгэхээр сая юу болчхов гэхээр одоо энэ уг нь анх яригдаж байсан юман дээр бол бид бас жоохон өргөн хүрээтэй асуудлыг авч үзэж байсан. Сая Хууль зүйн сайд хэллээ. 119 хүний асуудал байгаа юм. Ерөнхийлөгч, Их Хурлын гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн Засаг дарга, тэгээд эхнэр, нөхөр, хамтран амьдрагч, хүүхэд гээд. Тэгэхээр энэ 119 хүний эрхийг бол хязгаарлалт тавихдаа тэр хамаарал бүхий этгээдэд нь тавьж байгаа нь бол олон улсын зүгээс ч гэсэн яг энэ эрх мэдэлд хамгийн ойр байгаа хэсэгтэй нь ингээд эрсдэлт эрсдэлтэй бүлэг учраас ингэж тавихыг бол зөвшөөрдөг.

Харин зүгээр нэг асуудал байгаа. Ёс зүйн хувьд бол ер нь хүүхэд байтугай өөрийнх нь яг ийм 119 албан тушаалтны дүү нар хуртэл асуудалд их холбогддог эсвэл хардаж сэрддэг хүмүүс. Эд нар хэвийн явдаг л даа. Олон юм байгаа. Одоо ч гэсэн тэгээд л бидэнд асуудлууд үүсдэг шүү дээ. Эргэн тойрны чинь хүмүүс тэр дүү чинь ингэчихлээ гээд. Энэ хууль гарснаар бол хаана хаана энэ 119 төрийн өндөр албан тушаалтныг бас хамгаалж байгаа юм. Төрийн нэр хүндийг хамгаалж байгаа юм. Ийм сэрдлэгүүд үүсэхгүй болчхож байгаа юм. Тэгээд энэ бол дандаа мөнхөд энэ хязгаарлалт байна гэж ойлгохгүй байгаа юм. Манайхыг илүү ялзарсан байна, авлигажсан байна, хүмүүсийн эсэргүүцэл, шүүмжлэл их байгаа учраас харин Монгол Улсын Ерөнхий сайд Оюун-Эрдэнэ энэ авлигатай тэмцэх хүсэл зоригийнхоо хүрээнд эрх баригч намынхаа даргын хувьд өөрөө энэ

төрийн өндөр албан тушаалд байгаа өөрийнхөө намын болон бусад хүмүүсийн энэ юман дээр хязгаарлалт тавьж, тэр намын намаа ч тэр, өөрийнх нь албан тушаалд тавьсан энэ намынхаа хүмүүсийг, төрийн албан тушаалтнуудаа ч тэр, гэр бүлийг нь ч гэсэн энэ бас нэг талдаа хамгаалж байгаа.

Нөгөө талаас иргэдийг ч гэсэн энэ 119 хүн бусдаас илүү үүрэг хариуцлага хүлээж байгаа учраас бусдаас илүү тэр хязгаарлалт хориглолтод орж байна гэдэг тэр итгэл үнэмшил тэр итгэл сэргэхэд бол энэ яалт ч үгүй. Энэ бол хэрэгжихгүй биш шууд хэрэгжинэ. Хэрэв энийг зөрчөөд юм явуулчихсан байх юм бол тэр Их Хурлын гишүүн, тэр албан тушаалтан бол огцруулах чөлөөлөх тэр асуудалд орно. Эрх биш хүүхдийнхээ хаана юу хийж байгааг бид нар бол мэдэх боломжтой байгаа юм.

Тэгэхээр сайн засаг гэдэг бол эрх мэдлээ өөрөө хязгаарладаг засгийг хэлж байгаа юм. Тэгэхээр манай энэ Засгийн газрын тэргүүний оруулж ирж байгаа Ерөнхий сайдын энэ оруулж ирж байгаа бодлого бол харин Монголын сүүлийн хэдэн жилийн түүхэнд бол анх удаа ингээд зоригтойгоор өөрсдөдөө хязгаарлалт тавьж байгаа. Ер нь бусдаас шаардана гэдэг бол эхлээд өөрсдөдөө шаардлага тавих, тэр ёс зүйн өндөрлөг дээрээ байх ёстой гэдэг энэ юмыг Засгийн газрын тэргүүн тавиад байгаа шүү дээ. Ёс зүйн өндөрлөг дээр өөрсдөө байж дараа нь юм ярина гэж байгаа.

Тэгэхээр энэ утгаараа бол энэ бол 119 хүний хүрээнд тавьж байгаа асуудал шүү. Энэ дотор мэдээж зарим нэг асуудлууд үүснэ. Түрүүн манай зарим гишүүдийн хэлдгээр тэр сонгох, сонгогдох эрхийн тухайд бол хязгаарлалт бол шууд бол тавьж бол болохгүй байх. Тэрийг сая Хууль зүйн сайд тайлбарлаад хэлчихсэн. Тэгээд энэ асуудал дээр бол манай Улсын Их Хурал энийг шийдэх юм бол энэ бол дараа дараачийн улсууд энэ бол бас нэг түүхэнд тийм том гарч байгаа

шийдвэрүүдийн нэг болно шүү гэдгийг би бол хэлмээр байна. Тэгээд энэ асуудал дээр харин ч тэр цаашид зарим улсуудын юм ороогүй байж байгаа шүү дээ. Тэр би түрүүн хэлсэн тэр улсууд. Тэгээд ер нь бидэндээ энэ бол амар байгаа юм. Яах вэ тэр зарим улсуудад маань хэцүү байгаа ч гэсэн нэгэнт л ингээд л тангараг.../минут дуусав/

Б.Энхбаяр: Үг хэлчихлээ Сүхбаатар гишүүн. Би нэг асуулт асуучихъя. Ганбат гишүүн асуугаад бас хариулт авч чадаагүй. Энэ хууль батлагдсанаар шууд үйлчилж эхэлнэ. Тэгэхээр Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн аймаг, нийслэлийн Засаг дарга нарын төрийн удирдах албан тушаал хашиж байгаа энэ хууль гарснаас чөлөөлөгдөх албан тушаалтнуудын судалгаа гарсан зүйл байгаа юу? Хэчнээн албан тушаалтан чөлөөлөгдөхөөр ийм судалгаа гарсан юм байгаа юу гэсэн ийм асуулт байна. Сайнзориг дарга 3 номерын микрофон.

П.Сайнзориг: Хурал даргалагч бас зөвшөөрвөл АТГ-ын төлөөллөөс бас нэмж мэдээлэл танд бас хүргүүлмээр байна. Энэ хуулийг дагаад Дагаж мөрдөх журмын тухай хууль бол хийсэн. Эргээд дээр дурдсан албан тушаалтнуудын эхнэр, нөхөр, хамтран амьдрагч, хүүхэд төрийн албаны удирдах албан тушаал, төрийн болон орон нутгийн өмчит компани, улсын үйлдвэрийн газрын гүйцэтгэх удирдлагаар ажиллаж байгаа бол тухайн этгээд нь 23 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн дотор холбогдох эрх бүхий байгууллагад мэдэгдэж, ажлаас чөлөөлөгдөх арга хэмжээ авна гээд энэ шилжилтийн зохицуулалт хийсэн.

Хуулийг бол бид хэд өргөн барихдаа ямар ч байсан хагас жилийн хугацаа өгнө гэдэг төсөөллөөр бас барьсан. Тэгэхээр яах вэ зүгээр хууль батлагдах цаг хугацаатай уялдуулаад энэ Дагаж мөрдөх журмын хуулиар бол нэг 6 сарын хугацаа өгч байгаа гэдэг зүйл байгаа. Зуун тэр

хориод албан тушаалтны хувьд бол ашиг сонирхлын мэдүүлгийг дийлэнх албан тушаалтан маань Улсын Их Хурлын Тамгын газар буюу энэ дотроо нэгж буюу Ёс зүйн байнгын хороондоо хөрөнгө, орлогын мэдүүлгээ гаргаж байгаа учраас бас яг энүүнтэй танилцаж, хэчнээн албан тушаалтан бас энэ хязгаарлалтад орж албан тушаалаа өгөх юм байна гэдэг судалгаагаар бол хийх боломжгүй байгаа. Энэ мэдээллийг хүрэх хуулийн өөрчлөлт нь бас өмнө нь хаврын чуулганаар батлагдсан. Заавал Ёс зүй, сахилга батын байнгын хорооны хариуцлагын байнгын хорооны дүгнэлтийг үндэслэн Авлигатай тэмцэх газар бас хянан шалгах байгаа учраас бас яг энэ талын мэдээлэл бас тодорхой түвшинд хязгаарлагдалттай байгаа учраас бас яг тоог бүрэн хэлэх бололцоогүй байна гэдэг зүйлийг танд хэлье.

Б.Энхбаяр: Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан гишүүд асуулт асууж дууслаа. Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү. Адъяаа гишүүнээр тасаллаа. Энх-Амгалан гишүүн үг хэлье.

Б.Энх-Амгалан: Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хувьд бол дэмжиж байгаа юм. Энэ бол бас яг авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, улс төрд нөлөө бүхий этгээдэд давуу байдал бий болгохоос нөлөөллөөс ангид байлгах гэсэн энэ санаанууд бол зөв.

Гэхдээ хууль санаачлагч нэг зүйлийг анхаараарай. Энэ Үндсэн хуулийн зөрчил рүү орчих вий дээ. Ажил мэргэжлээ сонгох нь чөлөөтэй гэдэг энэ 16.4, хэнийг ч боловсрол мэдлэг, нийгмийн гарал үүслээр нь ялгаварлан гадуурхаж болохгүй гэдэг энэ Үндсэн хуулийн заалтууд зөрчигдөөд батлагдсаныхаа

дараа тэгээд ҮХЦ рүү явчих вий дээ. Энэ талаас нь сайн харж анхаараарай гэж нэгдүгээрт хэлмээр байна.

Хоёрдугаарт та бүхэн маань энэ төрийн өндөр албан тушаалтан буюу Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Их Хурлын гишүүн энэ хүмүүс л хамаарах юм гээд байдаг. Гэтэл яг оруулж ирсэн энэ төсөл дээр чинь харахаар зэрэг 17.1-ээс гадна 18.1.1-д заасан төрийн захиргааны тэргүүн түшмэлүүд, 20.2 дахь хэсгийн Засгийн газрын агентлагийн дарга нар, Улсын Их Хуралд суудал бүхий намын дарга бөгөөд агентлагийн орлогч дарга нарын асуудал энэ дээр ороод ирж байна шүү. Тэгээд энэ төрийн албаны чадамжийг сулруулчих вий дээ энэ хууль гарснаар. Төрийн албанд итгэх итгэл бий болохгүй. Төрийн албанд ажиллаж байсан дор бол арай өөр юм хийж байсан нь дээр юм байна гэдэг ийм юм руу ороод нөгөө чадалтай, боловсрол, мэдлэгтэй ийм боловсон хүчин төрийн албанд байршихгүй байх, төрийн албанаас зугтаах, гарах ийм хөдөлгөөнүүд бий болчих вий дээ. Монгол төр бол бас чадамжтай байх ёстой шүү гэдэг талаас нь анхаараарай гэж хэлэх гэж байгаа юм. Өөр юмгүй.

Б.Энхбаяр: Адъяаа гишүүн үгээ хэлье.

Ш.Адъяаа: Энэ хуулийн төслийг зайлшгүй баталж гаргах нь нийгмийн шаардлага байна. Бид өнөөдөр энэ 30 жилийн хугацаанд энэ улс төрд нөлөө бүхий хүмүүсээс тендер албан тушаалын наймаа хийдэг энэ схем чинь өнөөдөр бий болоод Монгол Улсыг хөгжлийг гацаасан. Өөрсдөө ашигтай бүх зүйлийг л хийдэг ийм асуудал чинь өнөөдөр сэдэрч нийгэмд ямар асуудал үүсгээд байгаа билээ. Энэ Үндсэн хуулийн зөрчлийн тухай гишүүд яриад байна л даа. Ийм асуудал болохгүй гэж бодож байгаа. Яагаад гэхээр өнөөдөр нийт улсын ашиг сонирхлын эрхэмлэнэ л гэж бид бүгдээрээ л тангараг өргөж ийм байдлаар гарч ирсэн. Энд 200 хүний асуудал өндөр албан тушаалтан

тэр ТӨК-ууд тэрний ах дүү 20000 хүний асуудал ярья гэж бодоход 2 сая иргэний эрх ашигийн төлөө өнөөдөр бид энэ Монголын төр бодлого гаргах ёстой. 2 сая хүний эрх ашиг байна уу 20200 хүний эрх ашиг байна уу гэдэг дээр бид бодох ёстой.

Энэ нам нь, төр нь төлөвшөөгүй байгаа. Олон муу зүйлийн жишээнүүд өнөөдөр бид нэрвэгдсэн. Улс орон чинь ийм байдалд хүрсэн. Ард түмэн төрд итгэх итгэлээ алдарсан. Энэ Засгийн газрыг би тэгж дэмжиж байгаа юм биш. Зөв бодлого оруулж ирсэн хүн зарчмын хувьд дэмжиж байгаа юм. Энэ асуудал дээр бид нар хүний эрх, эрх ашиг гэдгээс хамгийн түрүүлж Монгол Улсын эрүүл саруул нийгмийн төлөө, нийт улсын эрх ашигийн төлөө энэ асуудлыг шийдэх ёстой. Энэ төрийн өндөр албан тушаалтнууд энэ хуульд хамрагдсан хүмүүс өөрсдийнх нь ах дүү, хамаатан садан, үр хүүхдийнх нь эрх ашиг хөндөгдөнө гэвэл энэ албан тушаалаа өгөөд нийт ах дүү нарынхаа төлөө явах ёстой ийм зарчим байх ёстой. Энийг бид өнөөдөр энэ байр сууриас хандаж энэ хуулиа батлахгүй юм бол бид нар тэр олон улсын өмнө хүлээсэн үүрэг, тэр Авлигын эсрэг конвенцод энэ Засгийн газар, Монголын төрийн хүлээсэн үүрэг хаана байх юм. Энэ дээр ийм л байдлаар бид хандах ёстой.

Энэ дээр бол энэ өндөр албан тушаалтнуудын үр хүүхэд тэдгээрийн хамаарал бүхий хүмүүсийн эрх зөрчиж Үндсэн хууль дээр зөрчигдөнө гээд тэгээд ҮХЦ дээр очиход нийт улсын эрх ашиг гэдэг юмыг л энд харагдах байх гэж бодож байгаа юм. Тийм учраас энэ хуулийг батлах нь Монгол Улсын эрх ашиг, нийт авлигагүй нийгэм, эрүүл нийгэм байгуулах төрийн бодлогын хамгийн зөв бодлого байх ёстой гэсэн ийм байр суурьтай байна.

Б.Энхбаяр: Миний хувьд бас нэг үг байгаа. Тэгэхээр ёс суртахуун унасан газар түүнийг нөхөх гэж хууль гарч ирдэг гэсэн үг байдаг. Нийгмийн бүхий л

харилцааг хуульчлах, зохицуулах нэгдүгээрт боломжгүй. Хоёрдугаарт энэ нь өөрөө бас түүний төлөө байх ёсгүй. Заавал бүгдийг хуулиар зохицуулах гээд байх шаардлагагүй. Хэрэв бүх асуудал дээр бас ёс зүй манлайлдаг байсан бол. Энэ ёс зүй бас доголдож, төрийн албыг төрлийн алба болгож, ураг төрлийн байдлаар, өв залгамжлуулах байдлаар, угсаа залгамжлах байдлаар ийм болж. Энэ нь нэлээн тийм авлига, ашиг сонирхлын нийгмийн шударга ёсны шаардлагыг унагасан ийм нөхцөл байдлууд гарсан учраас өнөөдөр арга ядсандаа бас Монгол Улсын Засгийн газраас Ерөнхий сайдаас улс төрийн манлайлал үзүүлж энэ авлигатай хийх тэмцлийг хууль, эрх зүйн нэлээн хатуу чанд аргаар хийе гэдэг энэ санаачилгын хүрээнд өнөөдрийн энэ хууль орж ирж байна гэж ингэж үзэж байна.

Хэрэв ийм нөхцөл байдал гардаггүй байсан бол заавал ийм хууль бол орж ирэхгүй байх байсан юм. Үндсэндээ Нямдорж нэг нь аав нь сайд, хүү Анхбаяр нь Төрийн нарийн гэсэн ийм юмнууд дадал болж олон нийтийг бухимдуулж, өнөөдөр хууль болж орж ирж байгаа байхгүй юу. Тэгэхдээ энэ хууль бол эргэж үйлчлэхгүй. Дараа дараагийн үеүдэд энэ хориглолт хязгаарлалт болж үйлчилнэ. Тийм учраас олон гишүүд бас энэ хууль Монгол Улсын Үндсэн хуульд заасан ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох энэ эрхийг хязгаарлах болох уу? Ингээд хэн нэгний хүүхэд, хэн нэгний эхнэр, нөхөр гэдгээр тэр хүний ажил мэргэжлээ эрхлэх энийг хязгаарлаж байгаа хэрэг болох уу, Үндсэн хуулийн зөрчил болох вэ гэдэг ийм асуудлыг бол бас нэлээн олон гишүүд хөндөж ярьж байна.

Улсын Их Хурлын ХЗБХ бол Улсын Их Хурлын бас мэргэжлийн Байнгын хороо. Тэр дотроо Улсын Их Хурал хууль тогтоох үйл ажиллагаа нь Монгол Улсын Үндсэн хууль зөрчигдөхгүй байх, зөрчсөн тийм хууль хэлэлцэгдэхгүй байх гэдэг дээр бас Улсын Их Хурлын манаачийн үүрэг гүйцэтгэдэг. Хуралдаан даргалагчийн хувьд бол мөн Улсын Их Хурлын тухай

хуульд зааснаар бас Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн хуулийг бас хэлэлцүүлэхгүй байх үүрэгтэй гэсэн ийм заалт байдаг юм байна лээ. Тэгэхээр миний хувьд нэг ийм горимын санал гишүүддээ бас энэ хэлэлцүүлгийн шатад гаргая гэсэн ийм бодол байгаа юм. Тэр нь энэ хуулийн төслийн нэгдүгээр зүйлийн нэг дэх хэсэгт Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Монгол улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн Засаг даргын эхнэр, нөхөр, хамтран амьдрагч хүүхэд, төрийн албаны удирдах албан тушаал эрхлэх, төрийн болон орон нутгийн өмчит компани, улсын үйлдвэрийн газрын гүйцэтгэх удирдлагад ажиллахыг хориглоно гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн нэг дэх хэсэгт Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байна. Мөн зүйлийн 2 дахь хэсэгт хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүй этгээд байна гэж заасан заасныг зөрчиж байгаа эсэх асуудал асуудлаар эхлээд эрх зүйн дүн шинжилгээ хийгээд, мэргэжлийн яг Үндсэн хууль судлаачид энэ түвшинд манай Тамгын газарт эрх зүйн дүн шинжилгээ хийх нэгж тусдаа байгаа.

Энэ дүн шинжилгээний газраар нэн яаралтайгаар энэ дээр дүгнэлт гаргуулаад, тэгээд дүгнэлт гаргаад энэний дараа хэлэлцэх эсэх асуудлаа чуулганы хуралдаанд хэлэлцэх эсэх асуудлыг нь оруулбал ямар вэ? Зарчмын хувьд бол бүх гишүүд бол дэмжиж байгаа. Миний хувьд ч гэсэн энэ зарчмыг бол дэмжиж байгаа. Тэгэхээр цаашидаа мэргэжлийн Байнгын хорооны хувьд Улсын Их Хурлын чуулган дээр бас энэ асуудал Үндсэн хуулийн сая дурдсан заалтыг зөрчсөн эсэх асуудал мэдээж бусад гишүүдээс хөндөгдөх байх. Энэ дээр эрх зүйн үндэслэл бүхий судалгаатай тайлбартай орох үүднээс Эрх зүйн дүн шинжилгээний газраар урьдчилж

тайлбар дүн шинжилгээ хийгээд, тэгээд орвол ямар вэ гэсэн ийм саналтай байгаа юм.

Тийм учраас Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 4.1.3-д горимын санал гэж Улсын Их Хурлын гишүүнээс зөвхөн хэлэлцэж байгаа асуудлаар болон тухайн асуудлыг хэлэлцэх дараалал журмын талаар гаргасан саналыг хэлнэ гэж заасныг баримтлан мөн хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэгт холбогдох Байнгын хороо хэлэлцүүлгийн явцад хууль тогтоолын төслийн талаар эрх зүйн дүн шинжилгээ хийж дүгнэлт гаргуулахаар шийдвэрлэсэн бол тухайн Байнгын хорооны дарга эрх зүйн дүгнэлт хийлгэх төсөл, төслийн тодорхой зүйл хэсэг заалт, гишүүний гаргасан саналын томъёоллын талаар албан бичгээр Тамгын газарт хүргүүлнэ гэж заасныг үндэслэл болгон хуулийн төсөлд эрх зүйн дүгнэлт гаргуулах горимын саналыг гаргаж байна.

Энэ горимын саналыг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулъя. Санал хураалт. Боломжит богино хугацаанд, ерөөсөө хамгийн боломжит богино хугацаанд. Үгүй ээ үгүй. Энэ үгүйсгэж байгаа юу биш шүү дээ. Дүн шинжилгээ хийе л гэж байгаа. Энэ санал дэмжигдсэнгүй. Одоо горимын санал дэмжигдээгүй учраас гишүүд үг хэлж дууссан.

Хуулийн төслийг би саналын томъёоллыг унших юм байна. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Гишүүдийн 72.7 хувийн саналаар хэлэлцэх эсэхийг дэмжлээ. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг

сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх талаарх хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Адьшаа танилцуулна.

16.00 цаг

Хоёр.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Дараагийн асуудалдаа оръё. Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх талаарх хэлэлцүүлгийг явуулъя. Төсөл санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Хишгээгийн Нямбаатар танилцуулна. Нямбаатар сайд.

Х.Нямбаатар: Баярлалаа Хууль зүйн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Засгийн газраас санаачлан боловсруулж Улсын Их Хуралд 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг ХЗБХ-ны 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы 2022 оны 12 дугаар сарын 23-ны нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх явцад Улсын Их Хурлын гишүүдээс хууль тогтоомж санаачлах эрхийн хүрээ хязгаартай холбоотой зохицуулалтад Монгол Улсын Их Хурлын тухай хуульд

зохицуулснаар үлдэх нь зүйтэй гэсэн санал гарсан бөгөөд үүнтэй холбогдуулан хууль санаачлагч хуулийн төслийг татан авсан билээ.

Хуулийн төслөөс хууль тогтоомж санаачлах эрхийн хүрээ, хязгаартай холбоотой зохицуулалтыг хасаж бусад зохицуулалтыг хэвээр үлдээн Засгийн газраас дахин боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бөгөөд хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг шийдвэрлүүлэхээр ХЗБХ-нд танилцуулж байна. Хуулийн төсөлд зарчмын шинжтэй дараах өөрчлөлтүүдийг тусгалаа.

Нэг.Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлд Засгийн газраас санаачлах хуулийн төслийг тусган төлөвлөдөг бөгөөд Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүнээс санаачлах хууль тогтоомжийн төсөлд хамаардаггүй тул уг үндсэн чиглэлийг Засгийн газар баталж, Улсын Их Хуралд танилцуулахаар өөрчлөх нь зүйтэй гэж үзлээ.

Өөрөөр хэлбэл Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хурлын гишүүн нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан бүрэн эрх хууль санаачлах эрхийн хүрээ хязгаарт багтаан хэдийд ч хууль санаачлах эрхтэй гэж үзсэн болно.

Хоёр.Олон улсын туршилагаас судлан үзээд хуулийн төслийн танилцуулгыг товч болон дэлгэрэнгүй хийхээр тусгаж дэлгэрэнгүй танилцуулгад хуулийн төсөл болон дагаж гарах хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт тус бүрээр өөрчлөлт оруулах болсон үндэслэл, шаардлага, хуулийн төсөлд хэрэглэсэн нэр, томъёо, ухагдахууны үүсэл, хуулийн төслөөр зохицуулж байгаа харилцаа түүний зохицуулалтыг хэрхэн ойлгох талаарх мэдээллийг оруулахаар заалаа. Ингэснээр хууль санаачлагч ямар агуулгаар холбогдох зохицуулалтыг

хуулийн төсөлд тусгасан талаар хууль хэрэглэх явцад ойлгомжгүй нөхцөл байдал үүсвэл танилцуулгад дурдсан тайлбарыг эх сурвалж болгон ашиглаж болох зохицуулалтыг тусгав.

Гурав.Хуулийн төсөлтэй холбогдуулан бусад хуульд заасан агуулга ижил боловч өөр бичилттэй тухайн нэр томъёог дагаж өөрчлөх шаардлагатай тохиолдолд холбогдох бүх хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай болдог. Тухайлбал Улсын Их Хурлаас 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдөр баталсан Зөвшөөрлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгатай холбогдуулан тусгай зөвшөөрөл гэсэн нэр томъёог зөвшөөрөл гэсэн агуулгаар өөрчлөхтэй холбоотой 70 хуульд өөрчлөлт оруулсан байдаг. Иймд хууль тогтвортой байх үүднээс хуулийн төсөлтэй холбогдуулан бусад хуульд заасан нэр томъёог ижил утгаар ойлгож, хэрэгжүүлэх, хэрэглэх, тайлбарлах хууль, хэрэглэх тайлбарыг хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалтад тусгаж болох зохицуулалтыг тусгалаа.

Дөрөв.Одоогийн хууль тогтоомжоор Улсын Их Хурлаас баталсан хуулиудын албан ёсны орчуулгыг хийх талаар ямар нэгэн зохицуулалт байхгүй бөгөөд хуулийн төсөлд хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хуулийн албан бус орчуулгын санд сан бүрдүүлж Хувийн эрх зүйн мэдээллийн албан ёсны цахим хуудсанд байршуулахаар хуульчилсан. Түүнчлэн хууль санаачлагч худалдаа хөрөнгө оруулалтын чиглэлээр боловсруулсан хууль тогтоомжийн төсөл болон энэ хуульд заасны дагуу судалсан судалгааны тайланг 60 хоногоос доошгүй хугацаанд эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд байршуулж санал авахаар тогтлоо. Ингэснээр Монгол Улс АНУ-ын хооронд байгуулж, Улсын Их Хурлаас соёрхон баталсан олон улсын худалдаа хөрөнгө оруулалтын асуудлаарх ил тод байдлыг хангах тухай хэлэлцээрийн худалдаа хөрөнгө оруулалтын тухай хууль

тогтоомжийг англи хэлээр хэвлэн нийтлэхээр заасан зохицуулалтын хэрэгжилтийг хангахын зэрэгцээ хуулийн албан бус орчуулгыг хийх нь бүхэлдээ судалгаа шинжилгээний болон эдийн засгийн ихээхэн ач холбогдолтой гэж үзэж байна.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хүчин төгөлдөр дагаж мөрдөхөөс өмнө Улсын Их Хурлаас баталсан хуулиудын англи хэлний албан бус орчуулгыг холбогдох байгууллагууд уг хуулийг дагаж мөрдөж эхэлснээс хойш 3 жилийн дотор хугацаанд хариуцан гүйцэтгүүлэхээр дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг боловсруулаа.

Тав.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан Улсын Их Хурлаас батлах шаардлагатай хөгжлийн бодлогын баримт бичигт Хууль тогтоомжийн тухай хуульд заасан үнэлгээ судалгааг хийх шаардлагагүй тул холбогдох өөрчлөлтийг тусгав.

Зургаа.Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх, үнэлгээ хийх аргачлалын давхардлыг арилгах Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн эрх зүйн үндсийг хуульчлах өөрчлөлтийг тусгалаа. Хуулийн төсөл нь бүхэлдээ хууль тогтоомжийн төсөл боловсруулахад иргэд хөрөнгө оруулагч нарын оролцоог хангах, санал авах, батлагдсан хууль тогтоомжийг сурталчлах, тэдгээрийг тэднийг мэдээллээр хангахад чиглэгдсэн гэж үзэж болно. Хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төслийн хэлэлцэх эсэхийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Б.Энхбаяр: Баярлалаа. хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Сайнзориг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн

нарийн бичгийн дарга, Шагдарсүрэнгийн Цолмон Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч, Хүрэлбаатарын Эрдэм-Ундрах Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал гэсэн албан тушаалтнууд оролцож байна. Төслийн үзэл баримтлалтай холбогдуулан төсөл санаачлагчаас асуух асуулттай гишүүд нэрээ өгнө үү. Адьшаа гишүүнээр тасаллаа. Мөнх-Оргил гишүүн асуултаа асууя.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа, товчхон гуравхан асуулт байна. Энэ хууль зүйн асуудал эрхэлсэн энэ 46¹.1 дээр хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хуулийн албан бус орчуулгын сан бүрдүүлж гээд байгаа юм. Тэгэхээр энэ батлагдсан хуулийнхаа орчуулах юм байна. Тэгэхдээ гол нь нөгөө нэг төслөө орчуулна гэдэг санаа нь бол явж байгаа. Тэрийг тодруулчихъя, явж байгаа байх гэж бодож байна, тодруулчихъя.

Хоёрдугаарт Хууль зүйн хэлний зөвлөл байгуулъя хүрээлэнгийн дэргэд гэсэн санал байгаа юм байна. Тэгээд Хэлний бодлогын үндэсний зөвлөлтэй хамтарч ажиллана гээд. Би ийм санал байх юм. Ерөөсөө хэлний бодлогын үндэсний зөвлөл дотроо хууль зүйн хэлний нэг тийм салбар зөвлөл байгуулаад ажиллуулчихвал илүү давхардал багатай амар юм биш үү? Энийг нэг бодооч. Энэ дээр санал юу байна вэ?

Гуравдугаарт Нямбаатар сайд энэ нөгөө дагаж мөрдөх журмын хуулиар бид нар нэг баахан байгууллагуудад өөрийнхөө үйл ажиллагаатай холбоотой хуулиудыг 3 жил дотор багтааж орчуул гээд үүрэгдэж байгаа шүү дээ. Энэний оронд ер нь Хууль зүйн яам, Гадаад яам 2 дундаа нэг ажлын баг гаргаад өөрсдөө тэрийг нь орчуулахгүй бол байна шүү дээ тэр байгууллагуудын орчуулга чинь байгууллага байгууллагаараа янз янзын нэр томъёотой, үг үсэгтэй, яг тулгаад ашиглах гэхээр ашиглахад хэцүү юм орж ирнэ дээ. Тэгээд та нарт орчуулчихсан

гээд хуулийн би заалт биелүүлчихсэн гээд орчуулчихсан гээд өгдөг, авъя авч болдоггүй, хэрэглэе хэрэглэж болдоггүй. Хуульд чинь хамгийн гол нь л нэр томъёо байгаа шүү дээ. Тэрний ард байгаа тодорхойлолт, тэр тодорхойлолтын үндэс суурийг нь тавьж байгаа эрх зүйн тэр концепц нь ойлголт нь. Тэрийгээ ойлгож орчуулахгүй бол ашиглахын аргагүй болно шүү дээ. Тэгэхээр дундаасаа нэг тийм ажлын хэсэг гаргаад юм уу эсвэл 3 жил ажиллах тийм бүтэц гаргаад тэрэн дотроо нөгөө эрх зүйн нэр томъёоныхоо жагсаалтыг эхэлж бүгдийг нь тодорхой гаргаж өгөөд, тэгээд олон улсын гэрээ конвенцынхоо Монгол орчуулгуудыг нэг жигдэлж аваад, одоо энэ үндэснийхээ хууль тогтоомжуудыг Англи хэлний орчуулгын нэгжийг тэлж аваад нэг ийм компани ажил хийчихвэл яасан юм бэ? Тэр нь илүү үр дүнтэй болох байх. Байгууллага болгонд даалгавар болгосноос ийм асуулт, санал байна.

Б.Энхбаяр: Нямбаатар сайд хариулъя.

Х.Нямбаатар: Тийм. Мөнх-Оргил гишүүний яг хэлж байгаа зөв л дөө. Юуны манай Ил тодын хэлэлцээрийн бид нарын хүлээсэн үүрэг бол төсөл байх үе шатаас нь эхлээд орчуулга хийгээд, хэлэлцүүлгийн явцад парламентын гишүүд уг бизнесийн эрх зүйн чиглэлийн хууль тогтоомжуудад ямар хандлагатай өөрчлөлтүүдийг оруулж байна, цаашид энэ Монголын төрөөс гаднын хөрөнгө оруулагчдад ямар хандлага барьж ажиллахаар байна гэдэг бүх юм үе шатаар нь орчуулга хийдэг байя гэдэг ийм агуулгаар орж ирж байгаа юм.

Хоёрдугаарт таны саяын ярьсан нөгөө Монгол Улсын хэлний зөвлөлтэй бид нар бас энийг хэлэлцүүлэг төслийн явцад бид нар бас ажлын хэсэг дээр ярьж үзсэн юм. Тэгээд энэ арай л холдоод байна. Хоёр гэвэл тэр нөгөө хэлний зөвлөл тэр бүр яг бид нарын нөгөө энэ хууль үйлдвэрлэх процесс шиг байнга хуралдахгүй байна. Тийм учраас Хууль зүйн үндэсний хүрээлэнгийнхээ дэргэд яамныхаа дэргэд

нэр томъёоны ийм жигдэршлийг хангаж байдаг, тэгээд энэ хуулийн нэр томъёо нэг агуулгатай хууль болгон дээр хүн, хуулийн этгээд, насанд хүрээгүй хүн, хуулийн этгээд ингээд өөр өөр нэр томъёо яваад байгаа энэ жигдэршлийг ч гэсэн хангая. Тэгээд хууль дээр хэрэглэгдэх нэр томъёог нэг мөр ойлгоод яамныхаа дэргэд байлгавал илүү хүртээмжтэй ажиллах юм болов уу гэсэн ийм агуулгаар орж ирсэн.

Гурав дахь асуултад хариулахад яах вэ Мөнх-Оргил сайд яг үнэндээ бид нарт санхүүжилт байхгүй учраас л энэ нөгөө төсөл санаачлагчид нь энийг л даалгаад яваад байгаа байхгүй юу. Та манай яаман дээр яг ийм өндөр түвшний орчуулагч 1500000 төгрөгийн цалинтай, шинжээч мэргэжилтнээр ажиллах хүн олдохгүй болчихоод л бид нар арга ядаад л гадаадтай байгуулсан ил тодынхоо хэлэлцээрийг хэрэгжүүлэхийн тулд ийм байдлаар л хуульчилж оруулж ирж байгаа юм. Тэрнээс одоо яг ийм түвшний мэргэжилтэн бол нэг 10000000 төгрөгийн цалинтай ийм нэг 5 хүнтэй нэгж байвал энийг маш хурдан л хийх байх. Тэгээд бид нарт тийм төсөв алга. Цахим кибер аюулгүй байдлын чиглэлээр ч гэсэн бид нар бас хүний нөөц дээр цалингийн тусдаа бодлого барихгүй бол бас л болж өгөхгүй байгаа. Тэгээд та хэдэд би зовлонгоо л ярилаа.

Б.Энхбаяр: Адьшаа гишүүн асуултаа асууя.

Ш.Адьяа: Хууль санаачлагчаас 2 асуулт асууя. Энэ Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал бол хамгийн анхаарал татсан асуудлын нэг. Энэ дээр бол энэ хууль санаачлах эрх бүхий Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын Их Хурлын гишүүдийн хууль санаачлах эрхтэй холбоотой асуудлаар энэ хуулийн хэлэлцүүлэг Улсын Их Хурлын чуулган дээр бас олон шүүмжлэл дагуулж, энэ Засгийн газар энийгээ татаж авч энэ Үндсэн хуульд нийцүүлж оруулж ирсэн

гэсэн ийм ойлголттой байна. Тэгэхээр энэ Засгийн газар үнэ үндсэн чиглэлтэй холбоотой л асуудлыг мөрийн хөтөлбөртэй холбоотой асуудлыг л санаачилна гэж ойлгож байна. Бусад асуудал дээр Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүд энэ үндсэн чиглэлтэй тэр Засгийн газрын хөтөлбөртэй холбоотой асуудал санаачлах эрх нь нээлттэй байна уу, хаалттай байна уу?

Нөгөө талаасаа энэ Хууль зүйн хүрээлэнгийн эрх үүргийг тодорхой болгоно гэсэн ийм нэг юм орж ирсэн байх юм. Тэр энэ юуг нь тодорхой болгох юм, ямар асуудал нь тодорхой бус байсан юм. Тэгээд ер нь энэ Хууль тогтоомжийн тухай хуулийг бид ер нь нэлээн сайн анхаарч үзэх ёстой. Сая манай Энхбаяр дарга ярьж байна л даа. Ингээд горимын санал гаргаад Улсын Их Хурлын дэгийн тухай хуульд заасны дагуу эрх зүйн дүгнэлт гаргана гэж гэдэг ийм нэг асуудал оруулж ирсэн Дэгийн тухай хуулийн 38-д. Үгүй ээ тэгтэл чинь энэ Үндсэн хуульд харшилж байна уу, харшлахгүй байна уу гэж дүгнэлт гаргах эрх нь энэ Улсын Их Хуралд байдаг юм уу? Одоо бид нар чинь нэг сүүлийн үед л нэг сонин асуудал яриад байдаг болсон шүү дээ. Үндсэн хуулийн цэц тэгж чиглэл өгсөн. Тэгээд бид Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулна ч гэх шиг.

Тэгээд Үндсэн хуулийн эрх мэдлийг энэ Улсын Их Хурал дээр хэрэгжүүлж болох юм уу? Хууль тайлбарлана гэдэг чинь Дээд шүүх байдаг. Үндсэн хууль зөрчсөн зөрчиж байгаа асуудлыг чинь Үндсэн хуулийн цэц яадаг. Тэгтэл Улсын Их Хурал урьдчилаад Үндсэн хууль зөрчсөн, зөрчөөгүй асуудлыг нэг Байнгын хороонд дүгнэлт гаргадаг энэ ийм хууль дээдлэх зарчимтай нийцсэн энэ юмаа бас Улсын Их Хурал энэ дэгийн тухай хуульдаа цаашид авч хаях ёстой шүү. Өнөөдөр энэ бид нар бол парламентын засаглалтай улс, олонх, цөөнхийн төлөөлөлтэй улс. Хууль дээдлэх зарчим гэдэг ийм зүйлийг хамгийн түрүүлж

ишидэх ёстой. Энэ дарааллаараа явах энэ зарчим дээр бол бид өнөөдөр энэ Хууль тогтоомжийн тухай хуулиараа энэ асуудал дээр анхаарах ёстой л гэсэн ийм л байр суурьтай байна.

Б.Энхбаяр: Сайнзориг дарга хариулъя, 3 номерын микрофон.

П.Сайнзориг: Адъяаа гишүүний 3 асуулт асуусны 2-т нь би бас хариулах бололцоотой байна. Тэгээд 2 асуултад хариулъя. Хууль санаачлах хүрээ хязгаар дээр бол энэ дээр бас хассан. Монгол Улсын Үндсэн хуульд 19 онд оруулсан нэмэлт, өөрчлөлттэй холбоотойгоор Улсын Их Хурлын тухай хуулийг батлахдаа тэнд хууль санаачлах хүрээ хязгаарыг яг Улсын Их Хурлын гишүүд, Ерөнхийлөгч, Засгийн газрын гишүүд дээр нь 38 дугаар зүйл дээр зохицуулчихсан байгаа. Бидний хувьд энэ тэр заалтыг ийшээ шилжүүлж тусгах нь зүйтэй гэж байсан боловч эндээсээ татгалзсан.

Өөрөөр хэлэх юм бол Улсын Их Хурлын тухай хуулиар бас Ерөнхийлөгч, Засгийн газрын хууль санаачлах хүрээ хязгаарыг бас зохицуулж байгаа нь тухайн хуулийн бас зохицуулалтын асуудал биш байна гэдэг анх хуулийн төслийг боловсруулж байхдаа уг нь бол дүгнэлтийг хийгээд, Хууль тогтоомжийн хууль дээр тусгах нь зүйтэй юм байна гэж явсан боловч бас гишүүдийн ярьж хэлж байгаа санал шүүмжийг бид нар тусгаад энэ зүйлийг бас энэ дээрээс хассан. Улсын Их Хурлын гишүүд болон Ерөнхийлөгчийн хууль санаачлах хүрээ хязгаартай холбоотой заалт Хууль тогтоомжийн хууль дээр байхгүй гэдэг зүйлийг бас танд хэлэх нь зөв байх.

Хоёрдугаарт энэ хуулийн бас нэг өөрчлөлт нь түрүүн Мөнх-Оргил гишүүний асуусан асуулттай холбоотойгоор бас нэмээд хариулъя. Нямбаатар сайд хариулсан. Одоогийн Хууль тогтоомжийн тухай хуулиар бас нэг хэлний нэр томъёоны зөвлөл бас Хууль зүй, дотоод хэргийн яам дээр ажиллах

ёстой байдаг. Бид хэд бас яг энэ чиглэлдээ мэргэшсэн боловсон хүчин байхгүй, төсөв санхүү бас муу учраас энийгээ бас гүйцэд хийж чаддаггүй. Энэ чиг үүргээ үндсэндээ Хууль зүйн үндэсний хүрээлэн рүү бас шилжүүлж, энэ дээрээ эрдмийн ажил хийдэг, судалгааны ажилтнууд бас нэлээдгүй байдаг учраас энийгээ түшиглэж бас энэ нэр томъёогоо бас жигдрүүлэх асуудлаа анхааръя гэж байгаа.

Хоёрдугаарт бас батлагдан гарсан хуулиудыг хууль батлах боловсруулах асуудалд бид анхаараад бол яг батлагдан гарсан энэ хуулиудын бас хэрэгжилтийг тогтмол хянаж байх асуудал байгаад байгаа юм. Тэгэхээр энийг бол бас яамнууд бас өөрсдийн хүч нөөцөөр хийхэд бас боломжгүй учраас суурь хуулиудыг бол үндсэндээ Хууль зүйн үндэсний хүрээлэн хэрэгжилтийг нь тогтмол хянаж тодорхой мэдээллүүдийг цуглуулж, ямар үр дүн гарч байна гэдэг зүйлүүдийг буцаагаад танилцуулж байх юм. Жишээ нь Эрүүгийн хууль, Зөрчлийн хууль байдаг юм уу, захиргааны чиг чиглэлээр байдаг юм уу, Иргэний хуулийн суурь суурь зохицуулалтуудыг бас Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн тодорхой ийм секторууд хувааж авч шүүхийн практик дээр юу болж байна, эрдэмтэн судлаачдын бүтээлүүд дээр юу болж байна. Ер нь дагаж гарсан дүрэм журмууд нь бас нийцэж байгаа юм уу, үгүй юу гэдэг энэ асуудлаас нь бүх хүчин зүйлсээс нь бас хуулийн хэрэгжилтийг тогтмол хийж байх энэ чиг үүргийг бид нар Хууль зүйн үндэсний хүрээлэндээ энэ хуулиар бий болгож өгч байгаа. Энийгээ бас цаашидаа илүү их хийж, хуулийг батлан гарсны дараах буюу сурталчлан таниулах, тэгээд эргээд энэ хуулийг дахиад сайжруулах ажлыг судалгаа шинжилгээтэй хийх үүднээс энэ Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн чиг үүргийг хуульд илүү их тодорхой болгож өгч байгаа гэдэг зүйлийг бас танд тайлбараар хүргэе.

Б.Энхбаяр: Миний энэ би нэг асуулт асууя. Хуулийн төслийн 7.4-д хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлийг Засгийн газар баталж, Улсын Их Хуралд танилцуулна гэсэн өөрчлөлт оруулах гэж байгаа юм байна. Одоо бол үндсэн чиглэлийг Засгийн газрын өргөн барьснаар Улсын Их Хурал хэлэлцэж баталдаг. Тэгэхээр энийг өөрчлөөд Засгийн газар баталдаг болъё, Улсын Их Хуралд бол танилцуулдаг байя гэдэг ийм өөрчлөлт орох гэж байгаа юм байна. Энэтэй холбоотойгоор хуулийн төслийн 112.8-д Засгийн газар энэ хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлийг баталснаас хойш ажлын 14 хоногийн дотор нэгдсэн хуралдаанд танилцуулахаар Улсын Их Хуралд бичгээр хүргүүлнэ. Нэгдсэн хуралдаанд хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулна. Нэгдсэн хуралдаанаар танилцуулгыг 1 сарын дотор сонсох бөгөөд гишүүд танилцуулгатай холбогдуулан асуулт асууж, үг хэлж болно гэсэн ийм өөрчлөлт оруулъя гэж байгаа юм байна.

Энэ Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлийг Улсын Их Хурал баталдаг байсан нь байсныг Засгийн газар баталдаг болчихъё гэж өөрчлөлт оруулах болсны яг үндэслэл шалтгаан нь яг юу юм бэ? Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлийг Улсын Их Хурал баталдаг байхгүй юм уу гэсэн ийм асуулт байна. 3 номерын микрофон Сайнзориг дарга.

П.Сайнзориг: Энхбаяр гишүүний асуултад хариулъя. Ерөнхийдөө одоогийн Хууль тогтоомжийн тухай хуулиар энэ Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, урт хугацааны бодлогын бичиг баримттай уялдуулаад 4 жилийн дунд хугацааны төлөвлөлт байгаа, 4 жилийн. Энэ зөвхөн Засгийн газраас санаачлах хууль тогтоомжийн жагсаалт байдаг. Энэ жагсаалт нь бас заримдаа ингээд улс төрийн ээлжит

сонгуулийн дараах хийсвэр байдлаар гараад байгаа, судалгаа шинжилгээ байхгүй. Яг тухайн хууль дээр тандан судалгаа байхгүй, хэрэгжилтийн үр дагавраа үнэлээгүй байж баахан хуулийн жагсаалтыг Улсын Их Хурлаар батлуулаад байдаг. Тэгэхээр бид нар энийгээ илүү их үр дүнтэй болгоё гэж байгаа.

Хоёрдугаарт сая 19 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр хууль санаачлах хүрээ хязгаарыг бас үндсэндээ тодорхой зааглаад өгчихсөн. Энийгээ бид нар Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 38 дугаар зүйл дээр Засгийн газар нь ямар хуулиуд санаачлах юм, Ерөнхийлөгч ямар хууль санаачлах вэ, Улсын Их Хурлын гишүүд ямар хууль санаачлах вэ гэдгээ зааглачихсан учраас энийгээ заавал Улсын Их Хурлаар ээлжит сонгуулийн дараа оруулж, батлуулах гэдэг юм уу үл ойлголцлууд заримдаа гардаг. Энэ Улсын Их Хурлын гишүүдийн хууль санаачлах хүрээ хязгаарыг хязгаарлаад байна ч гэдэг юм уу ийм зүйлүүд гаргахгүйн үүднээс Засгийн газар өөрсдөө батлаад, энэ мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэхэд ийм хууль, эрх зүйн шинэчлэлийг ингээд 4 жилдээ хийх нь гэдгээ батлаад Улсын Их Хуралдаа танилцуулъя гэж байгаа. Ийм байдлаар бас бусад улс орнууд бас явдаг.

Өөрөөр хэлэх юм бол БНСУ-ын бас парламент нь өөрсдөө бас энэ дунд хугацааны хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлээ батлаад, парламентдаа танилцуулах ийм байдлаар явж байгаа учраас энэ өөрчлөлтийг хийж болох юм байна гэдэг үндсэн шаардлага хэрэгцээ байна гээд бас хуулийн төсөлд тусгаж оруулж ирсэн гэдэг зүйлийг танд хэлъе.

Б.Энхбаяр: Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан гишүүд асуулт асууж дууслаа. Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан үг хэлэх гишүүдэд нэрээ өгнө үү? Алга байна. Хуулийн төслийн үзэл баримтлалтай

холбогдуулан гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалт явуулна. Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 72.7 хувийн саналаар дэмжлээ. Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх талаарх хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Дэлгэрсайхан гишүүн танилцуулах уу? Дэлгэрсайхан гишүүн танилцуулна.

16.22 цаг

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА